



**“ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ” ХХК**

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН НУТАГ ДАХЬ ГАЗРЫН  
ТОСНЫ ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТЫН ТӨСӨЛ,  
“ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ” ХХК-НИЙ ХХІ ТАЛБАЙН 2022 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**ХАЛХГОЛ СУМ  
2022 он**

ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН НУТАГ ДАХЬ ГАЗРЫН  
ТОСНЫ ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТЫН ТӨСӨЛ,  
“ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ” ХХК-НИЙ ХХІ ТАЛБАЙ

2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар- 234, \2016.06.10\

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар- 2075385\

ХЯНАСАН:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах шинжээч: \_\_\_\_\_ \.....\

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ий

ХАБЭАБО хэлтсийн менежер: Б.Ариунболд \Б.Ариунболд\

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ий

ХАБЭАБО хэлтсийн байгаль орчны мэргэжилтэн: Б.Алтангэрэл \Б.Алтангэрэл\

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ий

ХАБЭАБО хэлтсийн байгаль орчны мэргэжилтэн: Э.Болорчимэг \Э.Болорчимэг\

2022 ОН

## АГУУЛГА

1. 2022 ОНЫ ОЛБОРЛОЛТ, ЭКСПОРТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн товч танилцуулга .....	3
1.2. 2022 оны Газрын тос олборлолт, экспортын мэдээ .....	7
1.3. БХГ-т XXI талбай дахь тос цуглуулах шугам хоолой ба олборлолтын нэгдсэн ил байгууламжийн төсөл.....	9
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ.....	12
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	12
2.1. Саармагжуулж хатууруулах техникийн нөхөн сэргээлт хийсэн газруудаас дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэх ажил .....	12
2.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажил.....	14
2.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нэмэлт ажлууд .....	15
2.4. Усан орчин. Газрын доорх ус.....	17
2.5. Газрын доорх усны мониторинг .....	19
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	20
3.1. Өрмийн шаврын хаягдлын санг саармагжуулж техникийн нөхөн сэргээлт хийсэн ажлын тайлан.....	21
3.2. Биологийн нөхөн сэргээлт .....	22
3.2.1. Олон наст ургамал тариалалт .....	22
3.2.2. Ногоон байгууламж болох мод тариалалт .....	23
3.3. Тэрбум мод үндэсний хөтөлбөр .....	24
4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	26
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	34
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ .....	34
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	34
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	35
7.1. Хүчтэй цасан болон шороон салхи, шуурга.....	37
7.2. Объектын болон хээрийн түймэр .....	37
7.3. Ган зуд .....	38
7.4. Зам тээврийн осол .....	39
7.5. Халдварт өвчин .....	39
7.6. Химийн бодисын асгаралт .....	41
7.7. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК химийн бодисын 2022 оны ашиглалтын мэдээ .....	42
8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	44

8.1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон ахуйн хог хаягдал .....	45
8.2. Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлсэн тухай.....	48
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	49
9.1. Агаар орчны хяналт шинжилгээ .....	51
9.2. Хөрсний орчны хяналт шинжилгээ .....	55
9.3. Усан орчны хяналт шинжилгээ .....	70
9.4. Ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээ.....	89
10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН.....	97
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	97
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	98
12. БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ.....	99



## 1. 2022 ОНЫ ОЛБОРЛОЛТ, ЭКСПОРТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн товч танилцуулга

Төсөл хэрэгжиж буй XXI талбай нь Монгол орны газарзүйн мужлалын хувьд Дорнод Монголын тал, хээрийн бүсэд хамаардаг бөгөөд харин засаг захиргааны өнөөгийн хуваарийн дагуу Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дэвсгэрт оршдог. XXI талбайн үйлдвэрлэлийн бааз нь Халхгол сумын төвөөс баруун зүгт 110км зайд, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос зүүн урд зүгт 220 км зайд оршдог.

Хөрөнгө оруулагч БНХАУ-ын газрын тос, байгалийн хий олборлолтын корпораци нь 2005 оны 8 дугаар сард “Соко Интернешил” ХХК-ийн хувьцааг худалдан авч Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (БХГ)–ний эрх үүргийг шилжүүлэн авснаар “Петрочайна Дачин Тамсаг (Монгол)” ХХК-ийг анх байгуулсан.


Газрын тос олборлолтын БХГ нь Хөрөнгө оруулагч болон Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулагдсан ба Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 1996 оны 8 тоот зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 1996.08.09-ний өдрийн 183 дугаар тогтоолоор зөвшөөрөгдөж, Монгол Улсын Засгийн газрын 1996.08.09-ний өдрийн 144-р тогтоолоор тус тус баталгаажсан.

Төсөл хэрэгжүүлэгч нь БХГ-ний дагуу Монгол Улсын үйлдвэр худалдааны яамны 2006.04.13-ны өдрийн 47 тоот “тусгай зөвшөөрөл” болон Уул уурхайн яамны сайдын 2012 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 72 дугаар тушаалаар олгосон “Аж ахуйн үйл ажиллагааны” 11 тоот зөвшөөрлөөр Дорнод аймгийн Тамсагийн сав газарт газрын тос олборлох үйл ажиллагаа явуулж байна.

БХГ-т талбайд XIX, XXI, XXII талбай тус тус хамаарч байсан бөгөөд XIX талбайн хайгуулын хугацаа 2010 онд, XXI талбайн хайгуулын хугацаа 2012 онд тус тус дуусаж үйлдвэрлэлийн олборлолтод шилжсэн. XXII талбайг эдийн засгийн үр ашиггүй гэж үзэн буцаах хүсэлтээ гаргасан. Төсөл хэрэгжүүлэгч нь БХГ-т XXI талбайд хайгуулын үеийн нийт 5278.2 км<sup>2</sup> талбайд үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Монгол улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 154 дүгээр тогтоолоор уурхайн эдэлбэр буюу ашиглалтын талбайг 209,2 км<sup>2</sup> байхаар багасган тогтоосон байна. Эргүүлэн олгох талбайн хэмжээ нь 5038,7 км<sup>2</sup> ба энэ хэсэгт нийт 7 газрын тосны хайгуул үнэлгээний цооног өрөмдсөн байна.

**Газрын тосны өрөмдлөг, олборлолтын техник, технологийн дараалал**  
 Газрын тосыг олборлох үйл явц нь дараах дарааллаар явагддаг.

**Өрөмдлөг → Цооногийн насос суурилуулалт → Олборлолт → Тээвэрлэлт**




Зураг-1. Олборлолтын техник, технологийн дараалал

**Өрөмдлөгийн дараалал, цооногийн гүн болон хугацаа:** Өрөмдлөгийн ажил нь өрөмдлөгийн цэгийг тогтоох, замын судалгаа хийх, суурь барих, цооногийн арамыг угсрах, нүүлгэлт хийх, тоног төхөөрөмжийг суурилуулах, анхны өрөмдлөг, хоёр дахь өрөмдлөг, өрмийг оруулах, гаргах, өрмийн хошууг солих, дахин

өрөмдөх, өрөмдлөг дуусах, цахилгаан тест хийх, бэхэлгээний хоолой суулгах, бэхжүүлэх гэсэн дараалалтай байна.

Өрөмдлөгийн ажил нь өрөмдөж эхлээд өрөмдөж дуусах хүртэл бүхий л ажлыг хэлнэ. Ихэнх тохиолдолд анхны өрөмдлөг, дээд давхаргад бэхэлгээний хоолой суулгах, бэхжүүлэх, хоёр дахь өрөмдлөг цооногт тест хийх болон цооногийн хананаас чөмгөн дээж авах, технологийн хоолой суулгах, бэхжүүлэх, гурав дахь өрөмдлөг, зорилтот цэгт хүрэх гэсэн дараалалтай байна.

Дундаж өрөмдлөгийн гүн 2100м, 1 цооногийг өрөмдөж дуусах дундаж хугацаа 20 хоног байдаг.



Зураг-2. Өрөмдлөгийн төхөөрөмжийн бүдүүвч зураг.

**Түүхий нефтийн насосын ажиллах зарчим болон бүрэлдэх хэсгүүд:** 21-р талбайд одоогийн байдлаар 310 цооног дээр морин толгой (насос) суурилуулан түүхий тос олборлож байна. Ажиллах зарчим → Цахилгаан мотор хүч дамжуулна. Хурд багасгагч төхөөрөмж цахилгаан моторын өндөр хурдыг хамгийн удаан

хурдтай болгож хөшүүрэг, холбогч гар, тэнцвэржүүлэгч бүтэц нь эргэлдэх хөдөлгөөнийг насосын давтамжит хөдөлгөөн болгож хувирган гүн цооногийн насосын үүргийг гүйцэтгэнэ.

1. **Хүч үүсгэх төхөөрөмж:** Цахилгаан төхөөрөмж нь насост үндсэн хүч дамжуулна.

2. **Хурд багасгагч төхөөрөмж:** Хурд багасгагч нь цахилгаан моторын өндөр хурдыг багасгаж тахир тэнхлэгийн хамгийн удаан хөдөлгөөнийг үүсгэж хөшүүргийн тэнцвэртэй байдлыг хангана.

3. **Хөшүүрэг, холбогч гар, тэнцвэржүүлэгч бүтэц:** Цахилгаан моторын эргэлт нь морин толгойн дээш доош хөдлөх хөдөлгөөнийг үүсгэнэ. Холбогч гар нь тэнцвэржүүлэгчийн дээд хэсэгт холбогдож хөшүүргийн үзүүр доод хөшүүрэгт холбогдож хүч дамжуулна. Тэнцвэржүүлэгч нь араман дээр бэхлэгдэх бөгөөд урд хэсэг нь морин толгойд бэхлэгдэж ачаалал авна. Хойд хэсэг нь тэнцвэржүүлэгч, холбогч, хөшүүрэг, хурд багасгагчид холбогдож цахилгаан моторын хүчийг дамжуулна.

4. **Бусад хэсэг:** Морин толгой нь тэнцвэржүүлэгчийн урд хэсгийн нуман хөдөлгөөнийг хувиргаж насосын шахагч гол эгц шулуун хөдөлгөөнд орно. Мөн насос ажиллах үед шахагч гол цооногийн амсрын төвд чиглэх бөгөөд цооногийн гүнд даралт өгөх үүрэгтэй. Холбогч нь шахагч гол болон морин толгойг холбосон зөөлөн чанартай эд анги бөгөөд хүчний тестерт график зураг гаргахад ашиглагдана. Арам нь дунд тэнхлэгт тулгуурлан тэнцвэржүүлэгчийг тулж шат болно. Түүхий нефтийн насосын суурь дээр насосын бүх жин төвлөрнө. Хундаам нь хүнд жингийн улмаас түүхий нефтийн насосын газарт суухаас хамгаална.

**Түүхий тос хадгалах сав:** Цооног бүрийн хажууд түүхий тос түр хадгалах сав буюу танк байна. Цооног бүр дээр 1 танк байрлах бөгөөд түүний багтаамж нь 32тн байна. Танканд хуримтлагдсан түүхий тос нь хэсэг хугацааны дараа хүндийн жингийн улмаас ус, тосны үеийг үүсгэдэг. Ус нь хүндийн жингээрээ доод талд нь тунах бөгөөд энэ усыг цистернээр зөөн үйлдвэрлэлийн шингэн хаягдлын түр санд хуримтлуулдаг.

**Нефть дамжуулах хоолойн бүтэц:** Нефть дамжуулах хоолой нь ган бүтэцтэй байна. Ган хоолойн гадуур дулаан алдахаас сэргийлсэн материалаар бүрсэн байдаг. Мөн ган хоолойг халаагч утсаар халааж түүхий тосны

температурыг хэвийн байдалд хадгалдаг. Ган хоолой нь цооногийн толгойгоос түүхий тос түр агуулах танк хүртэл дунджаар 15м үргэлжилдэг.

## 1.2. 2022 оны Газрын тос олборлолт, экспортын мэдээ

Газрын тос олборлолтын БХГ Тамсаг XXI талбайд нийт 572 цооног гарган ашиглах төлөвлөгөөтэй байна. Үүнээс 430 нь олборлолтын цооног, 142 нь ус шахалтын цооног байна. Тос олборлолтын хэмжээг жилд  $75.33 \cdot 10^4$  тн байхаар тооцсон байна. 2022 онд нийт 463 цооногийг ашиглаж байгаагаас 310 тос олборлолтын цооног, үүнээс 294 цооног нь нэгдсэн байгууламжинд холбогдсон бол 16 нь нэгдсэн байгууламжинд холбогдоогүй, 2022 онд нийт 153 нь ус шахалтын цооногийн зориулалтаар ашиглаж байна.

2013 оноос 2022 оны хооронд дох газрын тосны олборлолтын мэдээг графикаар үзүүлэв. 2022 оны олборлолтын хэмжээ  $\text{тн} \cdot 10^3$  (2022 оны 10-р сарын 25 байдлаар).




График-1. 2013-2022 оны газрын тосны олборлолтын мэдээ нь график

## Цооногийн өрөмдлөг, угсралтын ажил:

XXI талбайд 2022онд 10 цооног өрөмдлөгийн ажил хийгдээд байна. Газрын тосны хайгуул, олборлолт, үнэлгээний цооног өрөмдөх, цооног угсралт, ашиглалтанд шилжүүлэх ажил нь 2021 онд 5 цооног өрөмдсөн бөгөөд 2022 онд 2 цооног ашиглалтанд оруулсан, үүнээс 3 цооног ашиглалтанд ороогүй байна.



График-2. 2011-2022онд ашиглалтад орсон олборлолтын цооног

### **Газрын тосны олборлолт, экспорт:**

Петрочайна Дачин Тамсаг ХХК нь 2022 онд БХГ-т XXI талбайгаас нийт 1950210 баррель буюу 270.000 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байсан бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 25-ний өдрийн байдлаар олборлолтын цооногуудаас 807030.82 баррель газрын тос олборлож, 727152.92 баррель газрын тосыг ТА-2 олборлолтын ил байгууламжаас ачин Дорнод аймгийн Өвдөг-Баянхошуу боомтоор БНХАУ-руу экспортолсон байна.

2022 он	Олборлолт /тн/	Экспорт /тн/
1-р сард	2089.8	0
2-р сард	1148.06	0
3-р сард	1416.06	0
4-р сард	159.07	0
5-р сард	190.92	0
6-р сард	214.76	3153.93
7-р сард	23506.76	21677.53
8-р сард	35044.52	35187.77
9-р сард	33836.82	36325.3



10-р сард	30630.35	19200.1
11-р сард		
12-р сард		
<b>Нийт</b>	<b>128237.12</b>	<b>115544.6</b>

Хүснэгт- 1.2022 оны 10-р сарын 25-ны байдлаар

### 1.3. БХГ-т XXI талбай дахь тос цуглуулах шугам хоолой ба олборлолтын нэгдсэн ил байгууламжийн төсөл.

XXI талбайн ТА-2 олборлолтын нэгдсэн ил байгууламжийг 2014 оны 09 дүгээр сарын 13-ний өдөр ашиглалтанд хүлээн авсан. Цооногуудаас олборлох тосны гарцыг сайжруулах, олборлосон тосноос ус болон хийг өндөр түвшинд ялгах, олборлолтын цооног болгоноос машинаар зөөж байсан тосны шингэнийг дамжуулах хоолойгоор солин, тос тээвэрлэлт зөвхөн нэг станцаас явагдах болж машин замаар хөрс талхлагдах, бохирдох явдал эрс буурсан.



Зураг-3. ТА-2 олборлолтын нэгдсэн байгууламж

#### **Олборлолтын нэгдсэн байгууламжийн технологи ажиллагааны ерөнхий зарчим.**

Олборлолтын цооног → Тос цуглуулах шугам → Тос ус ялгах төхөөрөмж Тос цуглуулах үйл ажиллагаа:

Олборлолтын нэгдсэн байгууламж нь үйлдвэрийн баазын түр суурингаас баруун тийш 500 метр зайд байршина. Олборлолтын цооногуудаас тосыг дан болон давхар хоолойгоор халуун ус холих аргаар цуглуулна. Одоогийн байдлаар

310 цооног нэгдсэн байгууламжид холбогдсон байна. Харин ТА-2 нэгдсэн байгууламжид холбогдоогүй болон шавхалтын 78 цооногоос олборлосон тосыг автомашинаар ТА-2 байгууламж руу тээвэрлэн зөөж байна.

Олборлолтын цооног	ТА-2-т холбогдсон цооног	ТА-2-т холбогдоогүй олборлолтын цооног	Өндөр хүчдэлд холбогдсон
310	294	16	310

Хүснэгт- 2. XXI-р талбайн ашиглаж буй цооногууд

Олборлолтын цооногуудыг холбосон шугам хоолойн сүлжээнд тос цуглуулах ба ус хуваарилах дэд станц, ус шахалтын станц баригдсан. Нийт 15 дэд станц байна. Дэд станц бүрд цооногуудыг цагирагаар холбосон байдаг. Олборлолтын цооногоор олборлосон шингэн ойролцоох тос цуглуулах дэд станцаар дамжин олборлолтын нэгдсэн байгууламж руу шахагдана. Олборлолтын нэгдсэн байгууламжаас шахагдсан ус нь хуваарилах дэд станцууд болон шахалтын станцаар дамжин шахалтын цооногоор газрын гүний давхарга руу шахагдана. Тос цуглуулах ба ус хуваарилах дэд станцууд нь бүгд хоорондоо холбоотой байна. Олборлолтын цооног бүрийн технологийн үзүүлэлтүүдийг автоматаар хянах бололцоотой.

Ус холих шугам хоолойг тос цуглуулах ба ус шахах хоолойтой нэг сувагт байрлуулснаар газар шорооны ажлыг хамгийн бага хэмжээнд хийж, хөрсний температурыг хадгалах, шугам хоолойн дулааны алдагдлыг багасгах ач холбогдолтой. Мөн дэд станцуудын шугам хоолойг хооронд нь цуваа холбосноор дулааны нөхцөл сайжирч холих усны тоо багасах ба тос цуглуулах ерөнхий системийн радиус багасаж үйл ажиллагааны зардал буурна.

Газрын тосыг ус, хийнээс ялгах ерөнхий технологи Усгүйжүүлэх станцаар боловсруулах шингэний хамгийн дээд хэмжээг 2009 оны олборлолтын удирдамж дээр тодорхойлж гаргасан ба 890 т/ө байна. Түүхий тосыг 2 үе шаттайгаар усгүйжүүлнэ. Үүнд: 1-р шат: 3 фазын сеператор 2-р шат: саванд тунгаах Энэ технологи нь үр дүн тогтвортой, эрчим хүч бага хэрэглэдэг, удирдлага хяналт сайтай, энгийн хялбар арга юм. Цооногийн шингэн нам температурын 3 фазын дегидраторт (усгүйжүүлэх төхөөрөмж) орж тос, ус, хий ялгагдана. Ялгасан тосоо 60 минут орчим тунгаагаад дараа нь халаах зууханд 600С температурт хүртэл халаана. Халаасны дараа 2-4 өдөр босоо саванд тунгаагаад автомашинд ачихад

бэлэн болно. Сеператороос гарсан хийг түлшинд хэрэглэснээр байгаль орчны бохирдлоос сэргийлнэ.

Хий үйлдвэрлэл болон ашиглалтын байдал: XXI талбайн ус, тос, хий ялгах ТА-2 байгууламж нь 2022 оны 10 сарын байдлаар нийт  $1962010\text{м}^3$  хий үйлдвэрлэснээс  $1912459\text{м}^3$  хийг дулаан үйлдвэрлэхэд ашиглаж,  $11343\text{м}^3$  хийг цахилгаан үйлдвэрлэхэд ашигласан байна.

№	Сар	Үйлдвэрлэсэн хий	Дулаанд ашигласан хий	Генераторт ашигласан хэмжээ
1	1-р сар	5178	3702	1476
2	2-р сар	7321	6879	442
3	3-р сар	29724	25172	4552
4	4-р сар	2228	1563	665
5	5-р сар	1	1	0
6	6-р сар	13	0	0
7	7-р сар	344512	343527	985
8	8-р сар	547206	545058	2148
9	9-р сар	522501	514906	612
10	10-р сар	503326	471651	463
11	11-р сар			
12	12-р сар			
Нийт		1962010	1912459	11343

*Хүснэгт-3. 2022 онд ТА-2 байгууламжаар үйлдвэрлэсэн хий /м<sup>3</sup>-ээр/*

Ус, тос, хий ялгах байгууламж ашиглалтанд орохоос өмнө хийг олборлолтын явцад цооногийн толгойн хаалтыг нээн байгальд шууд хаядаг байсан бол ТА-2 байгууламж ашиглалтанд орсноор олборлолтын явцад гарсан хийг дулааны энерги болгон халаах зууханд хэрэглэх болсон. Энэ нь байгальд ээлтэй ногоон технологи юм.  $1\text{ м}^3$  хийг шатаахад 8500 кКал дулааны энерги ялгардаг гэж үзвэл 2022 онд  $16.2 \cdot 10^9$  хэмжээний кКал дулааны энерги үйлдвэрлэн технологийн хэрэгцээнийхээ усыг халаах зууханд халаан хэрэглэсэн байна. Ус цэвэршүүлэх үйл ажиллагаа Ус цэвэршүүлэх үйл ажиллагаа нь дараах зарчмаар явагдана. Үүнд: Усны худаг → усыг хийжүүлэх → марганцтай элсэн шүүр → нарийн цэвэрлэгээний шүүр → цэвэр ус хураах сав → (исэлдэлт идэвхгүйжүүлэх хольц 30 мг/л тунгаар тасралтгүй нэмнэ, бактери, ариутгагч хольц 100 мг/л тунгаар 6-8 цагаар 5 өдрийн давтамжтайгаар нэмнэ) → ус хуваарилах дэд станц.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ПетроЧайна Дачин Тамсаг ХХК-ний ХХI талбайн газрын тосны өрөмдлөг, олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

### 2.1. Саармагжуулж хатууруулах техникийн нөхөн сэргээлт хийсэн газруудаас дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэх ажил

Саармагжуулж хатууруулах техникийн нөхөн сэргээлт хийсэн газруудаас дээж авах ажлыг байгаль орчны зөвлөх үйлчилгээ эрхэлдэг, мэргэжлийн байгууллага болох “Байгаль тандалт” ХХК-н гүйцэтгэсэн. Уг ажлын хүрээнд MNS3298-90 “Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд” стандартыг баримтлан, нийт 30 цооногийн нөхөн сэргээлт хийсэн талбайгаас хөрсний дээж авч “Геологийн төв” лаборатори болон Байгаль орчин хэмжилзүйн төв лабораториудад шинжлүүлсэн.

№	Цооногийн дугаар	Координат		№	Цооногийн дугаар	Координат	
		Х	У			Х	У
1	N696-454	116°48'14.29"	47°25'56.02"	16	I522-182	117°02'07.49"	47°39'35.17"
2	N508-264	116°57'09.57"	47°38'33.58"	17	N520-180	117°02'09.97"	47°39'41.42"
3	N510-262	116°57'21.60"	47°38'36.36"	18	N518-182	117°02'00.60"	47°39'43.49"
4	N508-260	117°57'24.12"	47°38'42.00"	19	N516-184	117°01'50.42"	47°39'46.50"
5	N508-256	116°57'32.47"	47°38'46.59"	20	N518-186	117°01'45.05"	47°39'39.55"
6	N510-254	116°57'48.93"	47°38'43.57"	21	N498-138	117°06'50.68"	47°44'33.79"
7	N508-252	116°57'48.39"	47°38'49.51"	22	N500-136	117°04'24.59"	47°41'20.77"
8	N508-248	116°58'01.94"	47°38'55.36"	23	N500-128	117°04'53.05"	47°41'29.35"
9	N506-250	116°57'51.53"	47°38'56.43"	24	N496-124	117°04'58.29"	47°41'44.85"
10	N506-246	116°58'02.97"	47°39'01.15"	25	N452-98	117°04'51.15"	47°43'18.27"
11	N504-248	116°57'55.16"	47°39'02.17"	26	N440-66	117°06'42.32"	47°44'17.93"
12	N504-246	116°58'03.12"	47°39'07.60"	27	N438-66	117°06'46.33"	47°44'23.47"
13	N504-206	117°00'01.85"	47°39'42.57"	28	N436-64	117°04'14.55"	47°41'23.30"
14	N522-188	117°01'44.16"	47°39'30.66"	29	N438-62	117°07'03.26"	47°44'28.84"
15	N520-184	117°01'56.49"	47°39'35.05"	30	N440-60	117°07'14.09"	47°44'25.52"

*Хүснэгт- 4. Дээж авсан цооногийн дугаар, координат*

Шинжилгээний үр дүнг MNS5850:2019 “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын хэмжээтэй харьцуулсан.

№	Сорьц авсан цэг	Кадьма (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Кобальт (Co)	Строни (Sr)
		мг/кг							
1	N696-454	<0.005	8	<0.005	<0.005	21.8	28.5	8.6	211.5
2	N508-264	<0.005	8.4	<0.005	<0.005	<0.005	26	8.8	252.6
3	N510-262	<0.005	7.1	<0.005	<0.005	<0.005	30.2	3.4	252.2
4	N508-260	<0.005	6.6	<0.005	<0.005	14.1	28.6	1.9	221.2
5	N508-256	<0.005	7.9	<0.005	<0.005	40.7	29.5	3	204.40
6	N510254	<0.005	7.8	<0.005	<0.005	<0.005	29.5	2.3	229.3
7	N508-252	<0.005	6.7	<0.005	<0.005	2.3	29.9	7.5	238.70
8	N508-248	<0.005	8.2	<0.005	<0.005	37.2	29.7	5.2	257.2
9	N506-250	<0.005	10.4	<0.005	<0.005	29.5	29.6	8.8	236.60
10	N506-246	<0.005	8.7	<0.005	<0.005	30.4	29.7	6.5	236
11	N504-248	<0.005	11.1	<0.005	<0.005	26.5	28.6	3.6	242.6
12	N504-246	1.2	7.1	<0.005	<0.005	8.5	29.2	2.6	266.6
13	N504-206	<0.005	4.2	<0.005	<0.005	14.1	29.4	0.2	162.50
14	N522-188	0.4	6.6	<0.005	<0.005	2.8	29.2	5.7	169.7
15	N520-184	<0.005	8.3	<0.005	<0.005	40.3	29	6	171.4
16	N522-182	0.1	7.8	<0.005	<0.005	0.8	30.3	4.2	240.5
17	N520-180	0.4	8.8	<0.005	<0.005	14.8	29.3	15.3	226.6
18	N518-182	<0.005	8.5	<0.005	<0.005	1.5	29.2	6.9	201.4
19	N516-184	2.2	5.6	<0.005	<0.005	14	27.7	<0.005	132
20	N518-186	0.1	4.9	<0.005	<0.005	9.1	30.6	0.2	200.1
21	N498-138	1.9	11.6	<0.005	<0.005	7.2	29.2	<0.005	228.4
22	N500-136	<0.005	10.5	<0.005	<0.005	17.4	30	6.5	204.4
23	N500-128	<0.005	5.2	<0.005	<0.005	2.3	29.5	2	191.8
24	N496-124	<0.005	5.5	<0.005	<0.005	<0.005	29.8	0.3	173.7
25	N452-98	<0.005	6.3	<0.005	<0.005	22	29.9	4.3	249.8
26	N440-66	<0.005	6.2	<0.005	<0.005	8.8	30.3	0.6	235
27	N438-66	1.5	4.7	<0.005	<0.005	11.6	29.1	3.2	178.7
28	N436-64	0.7	6.4	<0.005	<0.005	10.5	28	2.7	237
29	N438-62	<0.005	3.7	<0.005	<0.005	12.7	29.6	2.6	215.4
30	N440-60	<0.005	8.1	<0.005	<0.005	19	29.7	8.9	204.1
<b>MNS 5850:2019 /ЗДХ/</b>		<b>3</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>150</b>	<b>300</b>	<b>100</b>	<b>50</b>	<b>800</b>

Хүснэгт-5. Шинжилгээний үр дүн

Хөрсний органик биш бохирдуулагч бодисууд болох бодисууд болох Хүнсэл (As), Никель (Ni), Цагаан тугалга (Sn), Ванаций (V), Кобальт (Co), Хром (Cr), Зэс (Cu), Хар тугалга (Pb), Цайр (Zn), Мөнгөн ус (Hg), Стронций (Sr)-н агууламж MNS5850:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага тул стандартын шаардлага хангаж, уг цооногийн хөрснүүд нь хүнд металлаар бохирдоогүй байна.

XXI талбайн саармагжуулах хатууруулах техникийн нөхөн сэргээлтийн 30

цооногийн хөрсний дээжинд хийсэн шинжилгээний дүнгээр бохирдуулагч элементийн хэмжээ нь хортой болон аюултай агууламжаас давсан тохиолдол гараагүй тул хөрсний бохирдлыг арилгах, саармагжуулах, ухаж зайлуулах зэрэг арга хэмжээ авах шаардлагагүй байна. Өрмийн хаягдлын сангийн нөхөн сэргээлтийн ажил стандартын дагуу хийгдсэнийг гэрчилж байна.

## **2.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажил**

XXI талбайн газрын тосны олборлолт явуулах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нэмэлт тодотголын тайланг тогтвортой хөгжил, байгаль орчны зөвлөх үйлчилгээний "Цавчирын Хөндий" ХХК хийж гүйцэтгэсэн.

Байгал орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилго нь "Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт XXI талбайн олборлолтыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтын ажил" төслийн хүрээнд БОАЖЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан чиглэл, хувиарын дагуу төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон нийгэм эдийн засагт үзүүлэх гол болон болзошгүй нөлөөллүүд, эрсдэлийг үнэлэх, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж үнэлэлт дүгнэлт өгөх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оршино.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг "Цавчирын Хөндий" ХХК-ийн экспертийн нь төсөл хэрэгжиж буй талбайд хийсэн хээрийн хэмжилт судалгааны материал, ус, агаар, хөрсний шинжилгээний үр дүнгүүд, бүс нутгийн цаг уур орчны шинжилгээний газрын мэдээ мэдээлэл, тус талбайд өмнө хийгдсэн судалгаа шинжилгээний мэдээ материалуудыг ашиглан Байгаль орчин, Ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А-11 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал"-ын дагуу хийж, Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны ерөнхий шинжээчийн "Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас"-т дурдсан шалгуур үзүүлэлт, судалж үзэн тусгах асуудал, нэгдсэн дүгнэлтийн даалгавар, онцгойлон анхаарах зүйлсийг судалж үнэлэлт, дүгнэлт, зөвлөмждөө нарийвчлан тусгасан.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан нь Төслийн хураангуй", "Оршил", "Үйл ажиллагааны хүрээ", "Төслийн тодорхойлолт", "Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ", "Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ", "Осол,



эрсдэлийн үнэлгээ, менежмент", "Экологи эдийн засгийн үнэлгээ", "Гол үр дүнгүүд ба нэгдсэн дүгнэлт", "Ашигласан материал" гэсэн 10 бүлэг "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө" болон хавсралтуудаас бүрдэнэ.

### 2.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нэмэлт ажлууд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт
1	Хөрсөн бүрхэвч	Хөрсөнд тос нэвчихээс хамгаалах дэвсгэр	2022 онд цооног өрөмдлөгийн ажил 10, цооног үйлчилгээний ажил 63, шингэн хагалбарын ажил 6, пломер шахах 5 ажил хийсэн бөгөөд тухай бүрд нь хөрсөнд тос нэвчихээс сэргийлж дэвсгэр дэвсэн ажил гүйцэтгэсэн.
2	Ургамлан нөмрөг	Ашиглалтаас гарсан замыг хагалах, тэмдэгжүүлэх	Нийт 25.5км-ын урттай 18-92 метрийн өргөнтэй 100 га газрын ашиглагдахгүй замыг хагалан, борнойдож ашиглахгүй замыг нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэсэн.

#### 2.3.1. Хөрсөнд тос нэвчихээс хамгаалах дэвсгэр дэвсэх

2022 онд цооног өрөмдлөгийн ажил 10, цооног үйлчилгээний ажил 63, шингэн хагалбарын ажил 6, пломер шахах 5 ажлуудыг хийх үед тогтмол цооногийн толгой хэсэгт 8\*8м хэмжээтэй тос үл нэвчүүлэгч дэвсгэрийг давхарлаж дэвсүүлэх, тостой труба болон өрмийн суурь машинд хэрэглэгдсэн багаж төхөөрөмжийн дор дэвсүүлэн тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Мөн ашиглахгүй болсон дэвсгэрийг аюултай хог хаягдал гэж үзэж аюултай хог хаягдалд тушаах компанид шилжүүлсэн дэлгэрэнгүйг хог хаягдлын тайланд тусгав. Хавсралт хэсэгт зураг оруулав.

#### 2.3.2 Ашиглалтаас гарсан замыг хагалах, тэмдэгжүүлэх

"Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн 21 дүгээр талбайн олборлолтын бүс нутгаас экспортын зам болох нийт 58км зам дагуу олон салаа замуудыг хаах, хагалах, борнойдох, тэмдэгжүүлэх ажлыг барилга байгууламжийн угсралт

засварын БУ58-748\18 тоот тусгай зөвшөөрөлтэй 2093812 регистрийн дугаартай, 0711001038 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй “ЧИМЭРҮҮ” ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн. Нийт уг зам нь 25.5км-ын урттай 18-92 метрийн өргөнтэй 100га газар юм.

Буйр нуурын өмнөд хэсэг Булан дэрсний хоолой, Зүүн шавар, Дунд шавар, Баруун шавар гэдэг газруудад хамаарах бөгөөд 100 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрын координат:

Солбицол		
Эхлэлийн цэг	Уртраг	E117 <sup>0</sup> 7'16.724"
	Өргөрөг	N47 <sup>0</sup> 37'53.073"
Төгсгөлийн цэг	Уртраг	117 <sup>0</sup> 26'45.153"
	Өргөрөг	47 <sup>0</sup> 35'49.137"

Хүснэгт-6. Техникийн нөхөн сэргээлтийн солбицол

### Нийт талбайн тооцоолол

Нөхөн сэргээлт хийсэн газрын талбайг тооцоолохын тулд нэг километр тутамд замын өргөнийг 3-4 удаа хэмжин дундаж өргөнийг гаргасан. Нэг километрийн талбайг хэмжээг гаргахдаа нэг километрийн урт болон дундаж өргөн үржвэрээр тооцсон. Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралтад харуулав. Нийт талбайн хэмжээ 100.04га болж байна. Харин талбайг хэмжээг 1м<sup>2</sup> -аар илэрхийлбэл 1000370 м<sup>2</sup> болж байна. Нийт 25.5 км үргэлжлэх замын талбайг 1 км тутамд талбайг тооцоолон метр квадратаар илэрхийлсэн зураглал:




График- 3. Ашиглахгүй болсон замын нийт талбайн хэмжээг график үзүүлэв.

## 2.4. Усан орчин. Газрын доорх ус

XXI талбайд гадаргын усны илэрц байхгүй бөгөөд унд, ахуйн болон технологийн зориулалттай ус хангамжийн эх үүсвэр нь газрын доорх ус байдаг. XXI талбай нь сав газрын ангиллаар Мэнэнгийн талын сав газар, Буйр нуур-Халх голын сав газарт хамаарч байна.

21-р талбайн унд ахуй, газрын тосны хайгуул, өрөмдлөг, олборлолтын үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх усны хэмжээг жил бүр тооцоолон гаргаж холбогдох эрх бүхий байгууллага Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-аас 2022 оны 03-р сарын 14 өдрийн 05\243 тоот албан тоотой “Ус ашиглуулах дүгнэлт” авсан. Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ны дүгнэлтийг үндэслэн 2022 оны 03-р сарын 24 өдрийн А\05 тоот албан тооттой “Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргааны даргын тушаал”-аар “Ус ашиглах зөвшөөрөл”, ус ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна.

2022 онд XXI талбайн хэмжээнд дараах байдлаар ашигласан байна.

1. Ажиллагсдын унд-ахуйн хэрэгцээ болон угаалгын хэрэглээ
2. Нефть олборлолтын технологийн хэрэглээ

1.Унд ахуйн хэрэглээнд: XXI талбайд ажиллагсдын хоол хүнс, унд ахуйн хэрэгцээний усыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын дагуу тооцдог бөгөөд 2022 онд унд ахуйд  $52'775.00\text{м}^3$  ус ашиглахаас 2022 оны 10 сарын 25-ны өдрийн байдлаар  $24'607\text{м}^3$  ус ашигласан байна.

Ахуйн хэрэглээний усыг ажилчдын суурингийн дэргэдэх Т21-W36 усны худгаас шугам хоолойгоор дамжуулан ахуйн хэрэглээнд нийлүүлдэг. Ахуйн бохир усыг XXI талбайн бохир ус цэвэршүүлэх байгууламж руу зөөвөрлөдөг.

Энэхүү ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламж нь 2014 оны 10 сард ашиглалтад орсон, 2017 онд өргөтгөл хийсэн бөгөөд газар дор булсан 2 тасалгаатай шүүх системтэй (хоногт  $250\text{м}^3$  бохир шүүх хүчин чадалтай) тус бүр нь 25 м3-ийн 10 септик-танк, лаг хаях нэг жижиг далангаас бүрдэнэ. Одоогоор лаг ялгаж хаяагүй байна.

Ахуйгаас гарж буй шингэн хаягдлыг ахуйн бохир хаях түр цэгт хүргэж байна. 2022 оны 10 сарын 25-ны байдлаар  $13'656$  тн шингэн буусан байна.

2. Нефть олборлолтын үеийн технологийн усны хэрэглээ: XXI талбайн 2022 оны олборлолт нэмэгдүүлэх цооног өрөмдлөг болон барилга байгууламж барих, нефть олборлох цооногийн ус шахалт, олборлолтын үеийн бүх шатны ажлуудад шаардлагатай усны хэмжээг ус ашиглах төлөвлөгөөндөө тусган холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аван ажилласан.

Тус төслийн хэмжээнд ус ашиглалтын төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн бааз дахь тос олборлох технологийн ус шахалт голлох байр суурийг эзэлдэг бөгөөд тос олборлох технологийн чухал нэг хэсэг юм.

2022 онд XXI талбайн газрын гүнээс унд, ахуйн хэрэглээнд зориулж  $52,575\text{м}^3$ , үйлдвэрийн технологийн хэрэгцээнд  $1'712'400.0\text{м}^3$  ус нийт  $1'764'975\text{м}^3$  усыг авч ашиглахаас унд ахуйн зориулалтаар  $24'607\text{м}^3$  үйлдвэрлэлийн зориулалтаар  $643'017\text{м}^3$  нийт  $667'624\text{м}^3$  ус олборлон ашигласан байна.

2022 онд унд ахуй болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд Халх гол сумын нутагт байрлах 35 усны худгийг тоолууртайгаар ашиглаж Дорнод аймгийн Татварын хэлтэст  $761'332'128$  төгрөгийг ус ашигласны төлбөр болгон төлж аймаг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

#### 2022 оны ашигласан усны хэмжээ, төлбөр

<b>Сар</b>	<b>Ашигласан усны хэмжээ /м3/</b>	<b>Нийт/төгрөг/</b>
1	99'665	118'003'360
2	72'504	85'844'736
3	98'866	117'057'344
4	66'052	78'205'568
5	60'301	71'396'384
6	54'806	64'890'304
7	45'356	53'701'504
8	72'407	85'729'888
9	73'060	86'503'040
10		
11		
12		
Нийт	643'017	761'332'128

Хүснэгт-7. 2022оны 01-сараас 10-р сарын ашигласан усны хэмжээ, төлбөр

ТА-2 байгууламжийн ус, тос, хий ялгах явцад гарсан 477'165 м<sup>3</sup> хаягдал усыг цэвэршүүлэн эргүүлэн ашигласан нь нийт газрын давхарга руу шахсан усны 62.0 хувийг эзэлж байна.

Сар	Цэвэршүүлсэн усны хэмжээ м <sup>3</sup> /
1 сар	21'236
2 сар	20'302
3 сар	24'606
4 сар	10'992
5 сар	7681
6 сар	9943
7 сар	75'001
8 сар	111'991
9 сар	101'642
10 сар	93'771
11 сар	
12 сар	
Нийт	477'165

Хүснэгт-8. 2022 онд саарал усыг эргүүлэн ашигласан хэмжээ

## 2.5. Газрын доорх усны мониторинг

XXI талбайн газрын тосны олборлолт явуулахад “ус шахалт”-ын технологийг 2012 оноос хойш нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн технологит газрын доорх усыг ашиглаж байна. 2016 оноос үйлдвэрлэлийн олборлолт ашиглалтын үед газар доорх усны түвшинг хэмжиж, тоо хэмжээг тогтоож, газар доорх ус ямар хэмжээ, чанартай байгааг хянах, газрын доорх усны мэдээллийн сан үүсгэх зорилгоор байнгын ажиглалт буюу мониторингийн хяналтыг хийн ажиллаж байна.

• **Гүний усны мониторингийн цооног өрөмдөж тоноглох:** “Байгаль Орчин Аялал Жуулчлалын яам”-аас баталсан ажлын даалгаврын дагуу үйлдвэрлэлийн олборлолт ашиглалтын үед газар доорх усны түвшинг хэмжиж, байнгын ажиглалт буюу мониторингийн хяналт хийх, газрын доорх усны мэдээллийн сан үүсгэх зорилгоор 17 цооногийг зохих арга аргачлал, технологийн дагуу 500 м гүнтэй өрөмдөж, тоног төхөөрөмж суурилуулах, хяналт шинжилгээ хийж байна. Мониторингийн худгийн хэмжилтийг сард нэг удаа гүний усны түвшний хэлбэлзлийг агуулсан мэдээллийг “Groundwater.mn буюу усны мэдээллийн нэгдсэн сан” –д оруулж байна.

### 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний XXI талбайн нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлсэн.

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Хэрэгжилт	Биелэлт
1	Техникийн нөхөн сэргээлт	Өрмийн шаврын хаягдлын санг саармагжуулж техникийн нөхөн сэргээлт хийх	5 ш	Бүрэн хэрэгжсэн.	“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-н 21-р талбайд 5 ширхэг өрмийн шаврын сангийн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг “Эко ургамал” ХХК хийж гүйцэтгэсэн. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй талбайг химийн бодис хийж саармагжуулах, тэгшлэх, засварлах, шимт хөрсөөр хучих ажил юм.
2	Биологийн нөхөн сэргээлт	Өрмийн шаврын хаягдлын сангийн техникийн нөхөн сэргээлт хийх, мод тариалах	2.4 га	Бүрэн хэрэгжсэн.	Өрмийн зүмпний техникийн нөхөн сэргээлт хийсэн 17 цэг, ашиглахгүй хассан замын техникийн нөхөн сэргээлт хийсэн 3 хэсэг газарт нийт 2.4 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн. Нөхөн сэргээлтийн ажлыг 8-р сарын 7-8 өдөр 1м <sup>2</sup> талбайд 600 грамм үр байхаар тооцож Ботууль, Хошоонгор, Согоовор, Ерхөг гэсэн 4 төрлийн ургамлын үрийг хольж тариалалт хийсэн. ТА-2 нэгдсэн байгууламжийн ачилтын талбайн хойд хэсэг, зам дагуу нийт 400 ширхэг 2 наст улиас мод суулгасан. Модны нүхийг 60см гүн, 80см диаметртэй ухаж бэлтгэн, усалж 2 метрийн өндөртэй улиасыг тариалав. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх үүднээс модны нүхний 50 хувьд хөрс, 30 хувьд элс, 20 хувьд бууц тооцож тариалсан. Уг ажлыг “Эко эрдэнэс бьюлдинг” ХХК хийж гүйцэтгэсэн.
3	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөр		14588 ширхэг	Бүрэн хэрэгжсэн.	“Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд кемпийн эргэн тойрон, ТА-2 нэгдсэн байгууламжийн урд талын гадаах талбай, зам дагуу нийт 4000 ширхэг чацаргана, 108 ширхэг нарс, 480 ширхэг улиас модуудыг тариалсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь нийгмийн хариуцлагын болон орон нутгийн хамтын ажиллагааны ажлын хүрээнд Дорнод аймгийн Халхгол суманд 10'000 ширхэг нарс модны суулгацыг хүлээлгэж өгсөн.



### 3.1. Өрмийн шаврын хаягдлын санг саармагжуулж техникийн нөхөн сэргээлт хийсэн ажлын тайлан

Тайлант онд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-н 21-р талбайд 5 ширхэг өрмийн шаврын сангийн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг “Эко ургамал” ХХК хийж гүйцэтгэсэн. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй талбайг химийн бодис хийж саармагжуулах, тэгшлэх, засварлах, шимт хөрсөөр хучих ажил хийгдлээ.

№	Цооногийн дугаар	Координат	
1	N476-82	N47 <sup>0</sup> 42'34.80"	E117 <sup>0</sup> 06'27.43"
2	N472-174	N47 <sup>0</sup> 41'32.07"	E117 <sup>0</sup> 00'45.63"
3	N486-198	N47 <sup>0</sup> 40'38.36"	E116 <sup>0</sup> 59'38.70"
4	N458-112	N47 <sup>0</sup> 42'27.58"	E117 <sup>0</sup> 03'35.53"
5	N454-87	N47 <sup>0</sup> 41'19.18"	E117 <sup>0</sup> 00'25.47"

*Хүснэгт-9. Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газрын солбицол*

Өрмийн шаврын санг хоргүйжүүлж саармагжуулсны дараа булж эргүүлэх аргыг олон улсын газрын тосны салбарт өргөн хэрэглэдэг. Энэхүү аргын гол технологи нь өрмийн шаврын санд саармагжуулах бодис хийж шаврын үлдэгдэл болох шингэн шавраа хөрс шороо маягийн эсвэл барьцамтгай чанар бүхий хатуу биет болгохын зэрэгцээ шаврын сангийн талбайг хоргүйжүүлж саармагжуулаад үржил шимт өнгөн хөрсөөр хучсанаар үүний үр дүнд тухайн газрын хөрсийг Монгол улсын хөрсний стандартад нийцүүлдэгт оршино.

Өрмийн шаврын хаягдлын санг саармагжуулах техникийн нөхөн сэргээлтийн ажлын дараалал дараах үйл явцтай явагдсан. Үүнд:

- Тор, шонг хураан авах
- Шингэнийг соруулах
- Өрмийн хаягдлын сангийн шингэн, шламны хэмжээг тодорхойлон хатаах, шингээх бодисын орц хэмжээг тогтоох
- Саармагжуулалт хийж экскаватороор хутгах, хатаах
- Шороон овоолгыг зөөж нүхэнд дүүргэлт хийх
- Үржил шимт хөрсөөр хучих
- Хүлээлгэн өгөх гэх мэт ажлын дараалалтай явагдана. Дэлгэрэнгүй тайланг техникийн нөхөн сэргээлтийн тайланд тусгав.

### 3.2. Биологийн нөхөн сэргээлт

#### 3.2.1. Олон наст ургамал тариалалт

Өрмийн зүмбийн техникийн нөхөн сэргээлт хийсэн 17 цэг, ашиглахгүй хаасан замын техникийн нөхөн сэргээлт хийсэн 3 хэсэг газарт бэлчээрийн чиглэлээр нийт 2.4 га талбайг биологийн нөхөн сэргээлтэнд бэлтгэсэн. Нөхөн сэргээлтийн 1м<sup>2</sup> талбайд 600 грамм үр байхаар тооцож Ботууль, Хошоонгор, Согоовор, Ерхөг гэсэн 4 төрлийн ургамлын үрийг хольж бэлтгэв.

Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн мэдээлэл			
№	Цооногийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	N519-169	47°39'51.46"N	117°02'27.67"E
2	N516-172	47°39'53.23"N	117°02'10.98"E
3	N516-168	47°39'59.15"N	117°02'21.79"E
4	N514-162	47°40'11.28"N	117°02'49.02"E
5	N514-174	47°39'55.26"N	117°01'57.33"E
6	N516-164	47°40'02.98"N	117°02'37.47"E
7	N514-166	47°40'05.29"	117°02'26.86"E
8	N514-178	47°39'51.43"N	117°01'41.63"E
9	N518-166	47°39'57.55"N	117°02'32.82"
10	N522-X186	47°39'25.05"N	117°01'21.32"E
11	N504-156	47°40'39.98"N	117°02'53.94"E
12	N502-152	47°40'49.33"N	117°03'06.24"E
13	N504-G152	47°40'47.85"N	117°03'05.57"E
14	N508-X153	47°40'44.32"N	117°03'05.57"E
15	N520-188	47°39'31.39"N	117°01'55.80"E
16	N520-172	47°39'44.72"N	117°02'16.74"E
17	N514-170	47°40'02.57"N	117°02'11.00"E
18	1-р талбай	47°39'2.65"N	116°59'20.18"E
19	2-р талбай	47°39'6.21"N	116°59'10.02"E
20	3-р талбай	47°39'7.54"N	116°59'57.52"E

Хүснэгт- 10.Нөхөн сэргээлт хийсэн талбайн координат

#### - Хөрс боловсруулалт

Олборлолтын үйл ажиллагааны нөлөөгөөр элэгдэлд орсон хөрсийг хошуут анжсаар хагалж, үүний дараагаар цант борнойгоор хавж бутлан, 3см\*3см\*3см байхаар сийрүүлж хөрсний боловсруулалтыг хийж гүйцэтгэв.

#### - Ургамал тариалалт

Олон наст ургамлыг энгийн мөрөөр буюу 15 см зайтай, 20:20:30:30 харьцаатай хольж тариалсан. 1га-д 58 кг, 1м<sup>2</sup> 600 грамм үрийг тариалсан. Ургамал

тарилтыг 2022 оны 8-р сарын 6-ний өдөр нийт 2.4 га талбайд бүрэн хийж гүйцэтгэсэн.

№	Ургамлын нэр	Тариалсан харьцаа
1	Согоовор	30
2	Ерхөг	30
3	Хошоонгор	20
4	Ботууль	20

*Хүснэгт-11. Холимог үр тариалалтын харьцаа*

### 3.2.2. Ногоон байгууламж болох мод тариалалт

Уг ажлыг газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага болох “Эко эрдэнэс бьюлдинг” ХХК нь хийж гүйцэтгэсэн. ТА-2 нэгдсэн байгууламжийн ачилтын талбайн хойд хэсгийн зам дагуу, туслан гүйцэтгэгч ангиудын гудамжинд нийт 400 ширхэг 2 наст улиас мод суулгасан.

- **Модны нүх бэлтгэх:** 2022 оны 8-р сарын 8-ний өдөр модны нүхийг ухаж бэлтгэсэн. Ойжуулалтын талбайн мод хооронд зайг 2 метр байхаар тооцож цагаан утсаар модны нүхний тэмдэг тэмдэглэгээ хийж гүйцэтгэв. Мод тариалалтад хэрэглэх 2 метрийн өндөртэй 2 настай улиас модыг Сэлэнгэ аймгийн Ерөө суманд байрлах “Тансаг ландшафт” ХХК –ийн мод үржүүлгийн газраас төслийн талбайд авчирсан. Модны хөрсний үр шимийг сайжруулахаар 1 мод тариалахад ухсан нүхийг 40 см дүүргэхээр 50 хувьд хөрс, 30 хувьд элс, 20 хувьд бордоо байхаар тооцож бордоог бэлтгэв.

- **Мод тариалалт:** Модны үндсийг жигд салаалуулан, ухаж бэлтгэсэн нүхний голд тэгш хэмтэй барив. Үүний дараагаар бэлтгэж боловсруулсан хөрсөөр тогооны ирмэгээс доош 20 см хүртэл дүүргэв. Мод суулгасны дараагаар жигд сайн гишгэж хөрсийг дагтаршуулан тогоог дүүртэл услав.

- **Модны усалгаа:** Мод тариалахаас өмнө модны нүхийг дүүртэл усалж мод тариалсны дараагаар дахин усалгаа хийж гүйцэтгэв. 1 модыг 70-80 литр усаар усалсан бөгөөд нийт 400 модыг 6.4 м 3 усаар услав. Намар болон хаврын цэнэг усалгаанд 1 модыг 40-50 литр усаар услах төлөвлөгөөтэй байна.

“Дорны Их Гэгээ” ХХК-тай тариалсан 400 модыг 1 жилийн хугацаад усалгаа хийхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Модны усалгааны хуваарийг дараагийн хүснэгтэд харуулав.

№	Модны нэр	Мод тариалахаас өмнө	Мод тариалсны дараа	2022 он		2023 он									
				сар		сар									
				X	XI	IV			V			VI			VII
				10 хоногоор											
III	I	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	
1	Улиас														

Тайлбар:

Өнгө	Өнгөний тайлбар
	Тариалалтын усалгаа
	Намрын цэнэг усалгаа
	Хаврын цэнэг усалгаа
	Улирлын усалгаа

Хүснэгт- 12. Модны усалгааны хуваарь

Мөн нөхөн сэргээлтийн талбайн тэмдэгжүүлэлт Ойжуулалт болон бэлчээрийн чиглэлээр нөхөн сэргээсэн талбайд тэмдэг тэмдэглэгээг байршуулав. \Хавсралт зураг\

**3.3. Тэрбум мод үндэсний хөтөлбөр**

3.3.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний ажлын хүрээнд “Петрожайна Дачин Тамсаг” ХХК нь дараах ажлуудыг хийсэн.

Хаврын мод тариалалтаар ажилчдын кемпийн эргэн тойрон, ТА-2 нэгдсэн байгууламжийн урд тал, зам дагуу нийт 4000 ширхэг чацаргана, 108 ширхэг нарс, намрын тариалалтаар 480 ширхэг улиас модуудыг тус тус тариалсан.

№	Модны нэр	Тоо хэмжээ	Байршил
1	Чацаргана	4000	ТА-2 нэгдсэн байгууламж, ажилчдын кемпийн эргэн тойрон
2	Нарс	108	Зам дагуу
3	Улиас	480	Ажилчдын кемпийн баруун тал

Хүснэгт-13.Мод тариалалт

3.3.2. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Петрожайна Дачин Тамсаг” ХХК нь нийгмийн хариуцлагын болон орон нутгийн хамтын ажиллагааны ажлын хүрээнд Дорнод аймгийн Халхгол суманд доорх нэр төрлийн модны суулгацыг хүлээлгэж өгсөн.

№	Сургалтын нэр төрөл	Тоо хэмжээ	Суулгацын нас	Суулгацын өндөр
1	Нарс	10.000	3-5 нас	30-60см

*Хүснэгт-14.Суманд хүлээлгэж өгсөн модны мэдээлэл*

## 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт
1	Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дэвсгэрт 2017-2021 онд хэрэгжүүлсэн Биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах талбайд мониторинг судалгаа хийх, үр дүнг тайлагнах,	2017-оос 2021 оны хооронд хэрэгжсэн дүйцүүлэн хамгаалах төслийн үр дүнг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж, дүгнэлт зөвлөмж бүхий тайлан гаргуулах	Уг ажлыг мэргэжлийн байгууллага болох ЕАСС LLC компаниар хийлгүүлсэн бөгөөд хээрийн судалгааны ажлыг 2022 оны 07 сарын 22-28 өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.
2	2023-2027 онд хэрэгжүүлэх “Петрочайна Дачин Тамсаг” ХХКийн “Тамсаг ХХI” талбайн биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулах	Биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг дахин хийлгэж хамгаалах арга хэмжээг тодорхойлуулах	Дорнод аймгийн Засаг даргын 2022 оны 03-р сарын 16 өдрийн 1\612тоот албан бичгийн дагуу дүйцүүлэн хамгаалах талбайн байршлыг өөрчлөн Буйр нуурын орчимд ойн зурвас байгуулах, мод тарьж ургуулах арга хэмжээг тусгах санал ирсэнтэй холбоотой дүйцүүлэн хамгаалах талбайн сонголтын ажил, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний 2023-2027 онд хэрэгжүүлэх биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж байна.



“Петрочайна Дачин Тамсаг” ХХК XXI-р талбай нь дүйцүүлэн хамгаалах талбайгаар Дорнод Монголын УТХГазар бөгөөд Лаг нуур, Вангийн цагаан уулын хойд, Сангийн далайн урд, баруун урд хэсэгт байх бөгөөд нийт талбайн хэмжээ нь 26,532 га талбай юм.

4.1. Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дэвсгэрт 2017-2021 онд хэрэгжүүлсэн Биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах талбайд мониторинг хээрийн судалгааг 2022 оны 07 сарын 22-28 өдрүүдэд ЕАСС LLC компаниар хийж гүйцэтгүүлсэн.

Дорнод аймгийн Халх гол сумын нутагт орших “Петро чайна Дачин тамсаг ХХК-ийн Тамсаг-XXI талбайн биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах ажлын 2017-2022 оны хооронд буюу 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөг байгаль орчны судалгаа үнэлгээний “Лэндс” ХХК 2016 онд боловсруулсан. Уг төлөвлөгөөг боловсруулахын тулд төслийн талбайн ойр орчимд биологийн олон янз байдлын суурь нөхцөл байдал буюу төлөв байдлын судалгааг 2016 онд хэрэгжүүлж Дорнод аймгийн Халх гол сумын нутагт орших Дорнод Монголын ДЦГ-т байрлах Вангийн Цагаан ууланд БОЯБС дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ төлөвлөх, хэрэгжүүлэх аргачлалд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд дараах 4 асуудлуудыг тусгана гэж заасан байна. Үүнд:

1. *Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдал анхаарах, тэдгээрийн төсөл хэрэгжихээс өмнөх суурь нөхцөл байдлыг тодорхойлох*

• Лэндс ХХК нь Тамсаг-XXI, Тосон-уул XIX талбайн биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулахаас өмнө биологийн олон янз байдлын төлөв байдлын судалгаа буюу хөрс, ургамлан нөмрөг, амьтны аймгийн суурь төлөв байдлын судалгааг хэрэгжүүлсэн байна.

2. *Биологийн олон янз байдлын хувьд ямар эерэг үр дүнд хүрэх зорилт, хэмжих шалгуурууд, биологийн олон янз байдлын мониторингийн төлөвлөгөө*

- Уг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлснээр 2032 он хүртэл биологийн олон янз байдал тэр дундаа Цагаан зээрийн нүүдэл шилжилт хөдөлгөөн, төллөх болон ороо хөөцөлдөөний нутаг тогтвортой болох,
  - Цайдам тойрмыг хамгаалснаар Дорнодын мэлхий хувьд тархцын хүрээ тэлж, тоо толгой тогтворжих,
  - Хонин тоодгийн хувьд өндөглөж зусах нутаг хамгаалагдаж, амьдрах орчин тэлсэн байх,
  - Монгол тарваганы хувьд хууль бус агнуур зогсож, Вангийн Цагаан ууланд үржлийн популяци бий болно.
  - Хялганат хээрийн зонхилогч болон дэд зонхилогч ургамлуудын өсөлт хөгжилт үзэгдэл зүй хэвийн явагдаж, бүлгэмдлийн дагалдагч 4 хуурайсаг үетэн ургамлуудын арви бүрхэц хэвийн байх, бүлгэмдлийн төлөв байдал 2016 оноос буураагүй байна.
  - Дэрвэгэр жиргэрүү ургамлын эзлэх талбай дүйцүүлсэн хамгаалсан газарт 10м<sup>2</sup> талбайд 7-8 бодгаль бий болж, хууль бус олборлолт зогссон байна.
  - Урт навчит Далан товч ургамлын бодгалийн тоо дүйцүүлэн хамгаалалт хийгдсэн газарт 10м<sup>2</sup> талбайд 2-3 болж, ургах орчин сайжирсан байна.
  - Урал чихэр өвс ургамлын бодгалийн тоо дүйцүүлэн хамгаалсан газарт 10м<sup>2</sup> талбайд 9-10 бодгаль бий болж, ургах орчин сайжирсан байна гэсэн зорилго зорилтуудыг тавьсан байна. Уг төлөвлөгөөгөөр 2032 он хүртэл хүрэх томоохон зорилго зорилт тавьсан болов ч төлөвлөгөөг хэрхэн хянах, ямар шалгуураар үнэлэх мониторингийн төлөвлөгөөг тайланд тусгаагүй байна.
3. *Биологийн олон янз байдлын хувьд эерэг үр дүнд хүрэх арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, Уг төлөвлөгөөнд 6 үндсэн зорилт бүхий 13 чиглэл, 52 арга хэмжээг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагдсан байна.*
- Зорилт 1: Дүйцүүлэн хамгаалалтад авсан газруудад менежментийн оновчтой бүтцийг бий болгож, чадавхыг бэхжүүлэх

- Зорилт 2: Дүйцүүлэн хамгаалсан газар нутагт ан амьтныг байгалийн нөхцөлд хэвийн өсөж үржих нөхцөлийг бүрдүүлэх
- Зорилт 3: Ургамлан бүрхэвчийг хамгаалах нэн ховор, ховор ургамлын нөөцийн хомсдолоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- Зорилт 4: Нутгийн иргэдийн оролцоотой хяналт, хамгаалалтын менежмент бий болгох
- Зорилт 5: Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн зохистой ашиглалтын талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх
- Зорилт 6: Уул уурхай болон хөгжлийн дэд бүтцээс шалтгаалан биологийн олон янз байдалд үзүүлэх шууд болон дам нөлөөллийг бууруулах гэсэн үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна.

#### *4. Арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагааг санхүүжүүлэх төсөв*

- “Тамсаг” XXI талбайн дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд арга хэмжээг, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зам чиглэлийг тусгасан болов ч үйл ажиллагааг санхүүжүүлэх төсөв зардлын үйл ажиллагаа бүрээр гаргаагүй байна. Харин ерөнхий мөнгөн дүнг MDT tool-ийн аргачлалын дагуу тооцож нэг жилийн дүйцүүлэн хамгааллын зардал нь дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбайн хэмжээг 2 төлбөрийн нэгж буюу 2\$-р үржүүлсэнд хүрэхүйц мөнгөн дүн гаргах хэрэгтэй гэж үзсэн байна.
- Тосон-Уул XIX-р талбайн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд арга хэмжээг, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зам чиглэлийг нарийн тусгаж зардал мөнгийг ажил бүрээр тооцож жил бүрийн зардлын тооцоог гаргасан байна. MDT tool-ийн аргачлалын дагуу тооцож нэг жилийн дүйцүүлэн хамгааллын зардал нь дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбайн хэмжээг 2 төлбөрийн нэгж буюу 2\$-р үржүүлсэнтэй тэнцэхүйц мөнгөн дүнг зарцуулна гэж  $48,682\text{га} \times 2\$ = 97,364\$$  зарцуулахаар тооцсон байна.

**Төлөвлөгөөний биелэлт<sup>1</sup>**

“Петрочайна Дачин тамсаг ХХК” -ийн Тамсаг-XXI талбайн биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө 2017-2022 онд тусгагдсан ажлуудыг хэрэгжсэн эсэхийг нягтлахыг тулд эхлээд Checklist буюу бүртгэн жагсаах аргаар үнэлж хялбаршуулсан. Уг бүртгэлийн жагсаалтад хэрэгжээгүй арга хэмжээг (x) тэмдэг шар өнгөөр илэрхийлсэн бол хэрэгжсэн арга хэмжээг (√) тэмдэг, ногоон өнгөөр тэмдэглэсэн (Хүснэгт-15.).

“Тамсаг XXI”-р талбайн биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах ажлын 2017–2022 оны төлөвлөгөөг Дорнод Монголын ДЦГ-т хэрэгжүүлсэн бөгөөд уг төлөвлөгөөнд тусгагдсан 6 үндсэн зорилт бүхий 13 чиглэлийн 52 үйл ажиллагааны хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		Биелэлт
<b>Зорилт 1. ДХ –д авсан газруудад менежментийн оновчтой бүтцийг бий болгож, чадавхыг бэхжүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байдал</b>		
1.1 Дүйцүүлэн хамгаалалтанд авсан газруудын эрх зүйн орчинг сайжруулах	1.1.1 Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий байгууллагад танилцуулах /2016 оны 11-р сарын 7-ны өдөр Чойбалсан хот танилцуулга хийсэн/	√
	1.1.2 Нутгийн өөрийн удирдах байгууллагын түвшинд дүйцүүлэн хамгаалалтанд авсан газрын дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэх	x
	1.1.3. Орон нутгийн өөрийн удирдах байгууллагын түвшинд харьяа нэгжүүдэд хамтран ажиллах	√
1.2.Хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх байгууллагыг тогтоох	1.2.1. Менежментийг хариуцагч байгууллагыг ажиллах нөхцөл, тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангах	√
	1.2.2. Менежментийг хэрэгжүүлэгч байгууллага, ажилтан, оролцогчдыг чадваржуулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	x
	1.2.3. Менежментийг хариуцагч байгууллага, албан тушаалтнуудад БОЯБ-ын хамгаалал, зохистой ашиглалтын сургалтуудыг үе шаттай зохион байгуулах	x
	1.2.4. Дүйцүүлэн хамгаалах газарт талуудын оролцоог хангах, үйл ажиллагааг зохицуулах (Хамтын менежментийн зөвлөл байгуулах гэх мэт)	x
	1.2.5. Дүйцүүлэн хамгааллын талаарх олон улсын болон үндэсний хэмжээний сайн туршлагаас судлах	x

<sup>1</sup> “Тамсаг XXI–р талбайн Биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө (2017–2022он)-ний биелэлт, гүйцэтгэлийг үнэлсэн тайлан” 5 үү

<b>Зорилт 2. Дүйцүүлэн хамгаалсан газар нутагт ан амьтныг байгалийн нөхцөлд хэвийн өсөж үржих нөхцөлийг бүрдүүлэх</b>		
2.1. Амьтны ажиглалт мониторингийн ажлыг тогтмолжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх	2.1.1. Ан, амьтны амьдрах орчинд нөлөөлөгч хүчин зүйл болох уур амьсгалын өөрчлөлт, цөлжих үйл явцад мониторинг хийх	√
	2.1.2. Цагаан зээр болон саарал чонын нүүдэл, шилжилт нөөцийн хөдлөл зүйг тодорхойлох, сансрын дохиоллын ажиглалт явуулах	x
	2.1.3. Байгаль хамгаалагчид болон мониторинг судалгаанд оролцогчдыг шаардлагатай техник, багаж хэрэгслээр хангах, био сан программд нэгтгэх /Мониторингийн оролцогчдыг судалгааны шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангасан/	√
2.2. Биотехникийн арга хэмжээ	2.2.1. Зэрлэг амьтдын усан хангамжийг сайжруулах зорилгоор тохиромжтой нутагт хөв цөөрөм байгуулах /6 цэгт хөв цөөрөм байгуулсан/	√
	2.2.2. Үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас оруулах	x
1	ББЕТ	1 мл-т 100-аас ихгүй	1 мл-т 48 цагт 46 ш илрэв	1 мл-т 48 цагт 52 ш илрэв
2	Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян	100 мл-т илрэх ёсгүй	Гэдэсний бүлгийн нян илрээгүй	Гэдэсний бүлгийн нян илрээгүй
3	Аммони	1.5 мг/л-ээс ихгүй	0.0 мг/л	0.0 мг/л
4	Кальци	100.0 мг/л-ээс ихгүй	2.004 мг/л	2.004 мг/л
5	Магни	30.0 мг/л-ээс ихгүй	1.22 мг/л	2.43 мг/л
6	Нийт төмөр	0.3 мг/л-ээс ихгүй	0.13 мг/л	0.0 мг/л
7	Нитрат ион	50.0 мг/л-ээс ихгүй	1.05 мг/л	0.99 мг/л
8	Нитрит ион	1.0 мг/л-ээс ихгүй	0.029 мг/л	0.027 мг/л
9	pH	6.5-8.5	6.77	6.55
10	Сульфат ион	500.0 мг/л-ээс ихгүй	4.0 мг/л	0.0 мг/л
11	Хатуулаг	7.0 мг-экв/л-ээс ихгүй	0.15 мг-экв/л	0.2 мг-экв/л
12	Хлорид	350.0 мг/л-ээс ихгүй	21.27 мг/л	28.36 мг/л
13	Хуурай үлдэгдэл	1000.0 мг/л-ээс ихгүй	70.0 мг/л	60.0 мг/л

Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2./Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй, өндөр эрсдэлтэй мал, амьтны гаралтайгаас бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлоход холбогдох хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна/-ийг үндэслэн Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын үзүүлэлттэй харьцуулан **ДҮГНЭХ нь:**

Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнгүүдээс үзэхэд:

Дорнод аймгийн Халхгол сумын нутаг, Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тамсаг-21 дүгээр талбайн T21-W27 худгийн усанд нянгийн тоо 10 ширхэгээр олон, төмрийн хэмжээ 0.05

мг/л-ээр олон, хлоридын хэмжээ 238.4 мг/л-ээр олон, хуурай үлдэгдэл 598 мг/л-ээр тус тус олон дүнтэй байгаа нь тус T21-W27 худгийн ус нь ахуйн ундны усны стандартын шаардлага хангахгүй байна.

Мөн гал тогоо, гэрээт ангийн усанд микроэлемент байхгүй дүнтэй гарсан тул эрдэсжүүлэн хэрэглэх нь зүйтэй байна.

Шинжилжилгээний дүн: №22-585

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 /Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана/ хэсэгт заасны дагуу хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй.

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ



Э.НОМИН

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ - *БС*

ГЭ ЮУФЭН

*Б.Мунгучев*


# Хавсралтууд



## 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний

### төлөвлөгөөний биелэлт

2.1. Саармагжуулаж хатууруулах техникийн нөхөн сэргээлт хийсэн газруудаас дээж авч лабораторын шинжилгээ хийлгэх



Зураг-1. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил



Зураг-2. Өгөгдсөн координатын дагуу цооног бүр дээр очиж, зураг авч баримтжуулсан



Зураг-3. Хөрсний дээж авахад ХАБЭАБО-ы хэлтсээс тавьж буй хяналт



Зураг-4. Дээж авахад АМГТГ-н төлөөлөгч хяналт тавьж байгаа нь




Зураг-5. Дээжийг талбайн булангийн 4 цэг, төв цэгээс авч,  
сайтар хольж, савласан





Зураг-6. Стандатын дагуу 40-50 см гүнээс хөрсний дээж авч байгаа нь

## 2.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажил



“Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Тамсаг ХХІ талбайн газрын тос олборлох төслийн”-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

**БҮЛГИЙН АГУУЛГА**

1	ТАЙЛАНГИЙН ТЕХНИКИЙН БҮС ХУРААНГУЙ	2
1.1	Төслийн хураангуй	2
1.2	Байгаль орчны өнөөгийн төлөв байдал	3
1.2.1	Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл	3
1.2.2	Уур амьсгал	3
1.2.3	Геологийн тогтоц ба геоморфологи	4
1.2.4	Гадаргын ус	6
1.2.5	Гидрогеологи	6
1.2.6	Хөрсөн бүрхэвч	8
1.2.7	Ургамалын нөмрөг	9
1.2.8	Амьтны аймаг	10
1.2.9	Тусгай хамгаалалттай газар нутаг	10
1.2.10	Нийгэм эдийн засаг	11
1.3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ	11
1.4	ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ТҮҮНИЙ МЕНЕЖМЕНТ	13
1.5	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13

Зураг-1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан



## 2.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нэмэлт ажлууд

### 2.3.1. Хөрсөнд тос нэвчхээс хамгаалах дэвсгэр дэвсэх




Зураг-1. Ажил эхлэхээс өмнө хөрсөнд тос нэвчхээс хамгаалан дэвсгэр дэвсэж буй байдал



Зураг-2. Ажил эхлэхээс өмнө хөрсөнд тос нэвчхээс хамгаалан дэвсгэр дэвсэж буй байдал



### 2.3.2. Ашиглалтаас гарсан замыг хагалах, тэмдэгжүүлэх



Зураг-1. Нөхөн сэргээлт хийж хагалсан газрын зураг



Зураг-2. Хагалаж буй байдал



Зураг-2. Хагалсан байдал



Зураг-4. Ажлын явцад тэмдэгжүүлсэн байдал





Зураг-5. Ажлын явцад тэмдэгжүүлсэн байдал



Зураг-6. Хагалсан шороог жижиглэж бутлаж буй байдал



### 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

#### 3.1. Өрмийн шаврын хаягдлын санг саармагжуулж техникийн нөхөн сэргээлтийн ажлын тайлан

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН, АЖИЛ ХҮЛЭЭЛЦСЭН ТУХАЙ АКТ

2022.10.25

Дорнод аймаг, Халхгол сум

“Эко Ургамал” ХХК- нь “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хайгуул, олборлолтын БХГ-т Тамсаг ХХИ талбайд өрмийн шингэн хаягдлын сан 5ш (N472-174, N476-82, N454-87, N458-112, N486-198), үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сан 1ш (ҮШХС-2019-1) дээр техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын “Байгаль Орчныг хамгаалах тухай хууль”, “Байгаль орчин, уул уурхай үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн шаардлага MNS5917:2008” стандартын дагуу техникийн нөхөн сэргээлтийг дараах ажлын дараалалтайгаар гүйцэтгэв.

1. Өрмийн шингэн хаягдлын сангийн шингэний хэмжээг тодорхойлон бодисын орц хэмжээг тогтоон өрмийн хаягдлын санд бодисоо хийж хутгасан.
2. Бодис хийсний дараа хатааж саармагжуулан хатуу төлөв байдалд орсны дараа шороон овоолгоор дүүргэлт хийж үржил шимт хөрсөөр хучсан.
3. Орчныг цэвэрлэгээг хийж гарсан хог, модон шон, төмөр тор зэргийг хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэн хүлээлгэн өгсөн.
4. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний Тамсаг ХХИ талбайн холбогдох удирдлагууд болон мэргэжилтнүүдэд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээлгэж өгсөн.

Захиалагч талыг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн БХГ-т Тамсаг ХХИ талбайн:

төлөөлж:

Дэд захирал ..... Ли Зонг Хуа

ХАБЭАБО-ны хэлтсийн менежер ..... Ан Пинг

ХАБЭАБО-ны хэлтсийн менежер ..... Б.Ариунболд

ХАБЭАБО-ны хэлтсийн БО-ны мэргэжилтэн ..... Б.Алтангэрэл

Гүйцэтгэгч талыг “Эко Ургамал” ХХК-ийн


төлөөлж:

Захирал: ..... н.Солонго

Талбайн инженер: ..... Н.Юмсүрэн

Зураг-1. Нөхөн сэргээлт хийсэн акт

### 3.2. Биологийн нөхөн сэргээлт



Зураг-1. Нөхөн сэргээлт хийгдсэн талбайн байршил

#### 3.2.1. 600 грамм үр байхаар тооцож Ботууль, Хошоонгор, Согоовор, Ерхөг гэсэн 4 төрлийн ургамлын үрийг хольж бэлтгэв



Зураг-1. Ургамлын үрийг хольсон байдал



Зураг-2. Ургамлын үрийг хольсон байдал

### Хөрс боловсруулалт



Зураг-1. Хөрс боловсруулалтын үйл явц-1





Зураг-2. Хөрс боловсруулалтын үйл явц-2

### Ургамал тариалалт



Зураг-1. Үр тариалагч





Зураг-2. Үр тариалж буй үйл явц

### 3.2.2. Ногоон байгууламж болох мод тариалалт



Зураг-1. Модны нүх ухагч трактор



Зураг-2. Модны нүх ухаж буй байдал



Зураг-3. Мод тарилтын бордооны бэлтгэл





Зураг-4. Мод тариалалт



Зураг-5. Мод усалгаа



### 3.3. Тэр бум мод

#### 3.3.1. Мод тарилт



Зураг-1. Модны нүх ухаж буй байдал



Зураг-2. Мод тариж буй байдал

### 3.2.2. Тэрбум мод

#### НОТЛОМЖ

Дорнод аймаг Халхгол сум

2022 оны 05 -р сарын 20

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнд зориулагдсан модны суулгацыг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-нь нийгмийн хариуцлагын болон орон нутгийн хамтын ажиллагааны ажлын хүрээнд Дорнод аймгийн Халхгол суманд доорх нэрийн модны суулгацыг хүлээлгэн өгч байна.

№	Сургалтын нэр төрөл	Тоо хэмжээ	Суулгацын нас	Суулгацын өндөр
1	Нарс мод	10 000	3-5 нас	30-60 см

#### Хүлээлгэж өгсөн:

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийг  
төлөөлж Дэд ерөнхийлөгч:  
/Сун Жиа Хуа/

Ашигт олборлолтын хэлтэсийн  
дарга:  
/Жан Ченг Ке/

Байгаль орчны асуудал хариуцсан  
ажилтан:  
/У.Начин/

#### Хүлээн авсан:

Дорнод аймгийн Халхгол сумыг  
төлөөлж Засаг даргын орлогч:  
/П.Итгэлтөгс/

“Халхгол Нэгдэл” ОНӨААТҮГ-ын  
захирал:  
/Б.Зоригтхүү/

“Халхгол Нэгдэл” ОНӨААТҮГ-ын  
Нягтлан бодогч:  
/Ганзориг Ч.Ганборигл/

Зураг-1. Тэрбум мод



#### 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



Зураг-1. Тамсаг булаг



Зураг-2. Вангийн цагаан уул

## 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлсэн тухай



Зураг-1. Эрээн хучлага



Зураг-2. Бодисын шуудай, арчих материал




Зураг-3. 18 л будагны сав, 60л химийн бодисын сав





Зураг-4. Галын хор



Зураг-5. Ремень, дугуй



# 10.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН, АЖИЛ ХҮЛЭЭЛЦСЭН ТУХАЙ АКТ

2022.10.25

Дорнод аймаг, Халхгол сум

“Эко Ургамал” ХХК- нь “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хайгуул, олборлолтын БХГ-т Тамсаг XXI талбайд өрмийн шингэн хаягдлын сан 5ш (N472-174, N476-82, N454-87, N458-112, N486-198), үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сан 1ш (ҮШХС-2019-1) дээр техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын “Байгаль Орчныг хамгаалах тухай хууль”, “Байгаль орчин, уул уурхай үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн шаардлага MNS5917:2008” стандартын дагуу техникийн нөхөн сэргээлтийг дараах ажлын дараалалтайгаар гүйцэтгэв.

1. Өрмийн шингэн хаягдлын сангийн шингэний хэмжээг тодорхойлон бодисын орц хэмжээг тогтоон өрмийн хаягдлын санд бодисоо хийж хутгасан.
2. Бодис хийсний дараа хатааж саармагжуулан хатуу төлөв байдалд орсны дараа шороон овоолгоор дүүргэлт хийж үржил шимт хөрсөөр хучсан.
3. Орчныг цэвэрлэгээг хийж гарсан хог, модон шон, төмөр тор зэргийг хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэн хүлээлгэн өгсөн.
4. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний Тамсаг XXI талбайн холбогдох удирдлагууд болон мэргэжилтнүүдэд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээлгэж өгсөн.


Захиалагч талыг  
төлөөлж:

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн БХГ-т Тамсаг XXI талбайн:

Дэд захирал

 Ли Зонг Хуа

ХАБЭАБО-ны хэлтсийн менежер

 Ан Пинг

ХАБЭАБО-ны хэлтсийн менежер

 Б.Ариунболд

ХАБЭАБО-ны хэлтсийн БО-ны  
мэргэжилтэн

 Б.Алтангэрэл

Гүйцэтгэгч талыг  
төлөөлж:

“Эко Ургамал” ХХК-ийн

Захирал:

 н.Солонго

Талбайн инженер:

 Н.Юмсүрэн

**"ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ" ХХК-ИЙН 21 ДҮГЭЭР ТАЛБАЙН  
АШИГЛАГДАХГҮЙ ЗАМЫГ ХАГАЛСАН АЖЛЫН АКТ**

2022 оны 09 дүгээр сарын 03

**Нэг талаас** "ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ" ХХК/захиалагч/ **нөгөө талаас** "ЧИМЭРҮҮ" ХХК/гүйцэтгэгч/ 2022 онд хэрэгжүүлэх "Петрчайна Дачин Тамсаг" ХХК-ийн байгаль орчныг хамгаалах төслийн хүрээнд 21 дүгээр талбайн ашиглагдахгүй замыг хагалах DQYT-GKGS-2022-FW-1115 тоот гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлүүд, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, стандартыг үндэслэн зам хагалах ажлыг чанартай сайн гүйцэтгэхэд оршино.

"ЧИМЭРҮҮ" ХХК нь барилга байгууламжийн угсралт засварын БУ58-748/18 тоот тусгай зөвшөөрөл бүхий 2093812 дугаартай регистртэй, 0711001038 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй мэргэжлийн ажилтан ажиллагсадтай өөрийн өмчлөлийн техник, машин механизм, тоног төхөөрөмжөөр хангагдсан хуулийн этгээд болно.

Тус ажлыг хийж гүйцэтгэхэд захиалагч талаас 21 дүгээр талбайн ХАБЭАБО-ын хэлтсийн менежер Б.Ариунболд, ХАБЭАБО-ын хэлтсийн дэд менежер Б.Сүхбат, ХАБЭА-н мэргэжилтэн Н.Цогтдэмбэрэл, ХАБЭАБО-ын хэлтсийн байгаль орчны мэргэжилтэн Б.Сүлдбаяр нар хяналт тавьсан.

Гүйцэтгэгч талаас захирал Ч.Чулуунбаатар, үйлдвэрлэл хариуцсан менежер Ж.Мөнхбат нараар ахлуулсан, менахик С.Өлзийхутаг, тракторын жолооч Ж.Энх-Адъяа, Д.Насантогтох, тогооч, гагнуурчин нарын 8 хүний бүрэлдэхүүнтэй 2 баг болон ажиллаа.

Дээрхи ажлыг Дорнод аймгийн Халх гол сумын 2 дугаар баг/Ялалт/-ийн нутагт байрлах "ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ" ХХК-ийн 21 дүгээр талбайн олборлолтын бүс нутаг дахь Буйр нуурын өмнөд хэсэг Булан дэрсний хоолой, Зүүн шавар, Дунд шавар, Баруун шавар гэдэг газруудад 25,5 километрийн урттай 18-92 метрийн өргөнтөй 100 га газрын ашиглагдахгүй зам хагалан, борнойдож нөхөн сэргээх ажлыг 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрөөс 08 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэлх хугацаанд, хагалсан

замыг хэмжих, замын тэмдэг тэмдэглэгээг дахин нэмж байршуулах, зарим нэгэн нэмэлт ажлуудыг захиалагчийн хүсэлтээр 08 дүгээр сарын 24-ны өдрөөс 9 дүгээр сарын 1-ны хооронд тус тус хийлээ.

Ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм мөн галын аюулгүй байдал, техник ашиглалтын горимыг ханган ажилласан.

Манай компани нь ОХУ-ын үйлдвэрлэсэн МТЗ-80 маркийн дугуйт тракторууд анжис, борной, том оворын ачааны машин, бага оворын ачааны портор, суудлын машин, гагнуурын зөөврийн аппарат, цахилгаан үүсгүүр, хийн компрессор, төмөр таслагч, дугуйт метр болон бусад тоног төхөөрөмжүүдийг ашигласан.

Ажлын гүйцэтгэлтэй холбоотой зургыг ажлын тайланд дэлгэрэнгүй тусгасан.

**ЗАХИАЛАГЧ:**

**АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:**

ХАБЭАБО-Ы ХЭЛТЭСИЙН МЕНЕЖЕР

АН ПИНГ/AN PING/

**АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВЬСАН:**

ХАБЭАБО-Ы ХЭЛТЭСИЙН ДЭД МЕНЕЖЕР

Б.СҮХБАТ

ХАБЭАБО-Ы ХЭЛТЭСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Б.СҮЛДБАЯР

**ГҮЙЦЭТГЭГЧ:**

ЗАХИРАЛ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МЕНЕЖЕР



Ч.ЧУЛУУНБААТАР

Ж.МӨНХБАТ



НОТЛОМЖ

Дорнод аймаг Халхгол сум

2022 оны 05-р сарын 20

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнд зориулагдсан модны суулгацыг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-нь нийгмийн хариуцлагын болон орон нутгийн хамтын ажиллагааны ажлын хүрээнд Дорнод аймгийн Халхгол суманд доорх нэрийн модны суулгацыг хүлээлгэн өгч байна.

№	Сургалтын нэр төрөл	Тоо хэмжээ	Суулгацын нас	Суулгацын өндөр
1	Нарс мод	10 000	3-5 нас	30-60 см

**Хүлээлгэж өгсөн:**

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийг  
төлөөлж Дэд ерөнхийлөгч:  
/Сун Жиа Хуа/

Ашигт олборлолтын хэлтэсийн  
дарга:  
/Жан Ченг Ке/

Байгаль орчны асуудал хариуцсан  
ажилтан:  
/У.Начин/

**Хүлээн авсан:**

Дорнод аймгийн Халхгол сумыг  
төлөөлж Засаг даргын орлогч:  
/П.Итгэлтөгс/

“Халхгол Нэгдэл” ОНӨААТҮГ-ын  
захирал:  
/Б.Зоригтхүү/

“Халхгол Нэгдэл” ОНӨААТҮГ-ын  
Нягтлан бодогч:  
/Ганборигил/

## ХАЛДВАРГҮЙТГЭЛ БОЛОН ШАВЖГҮЙТГЭЛ, МЭРЭГЧГҮЙТГЭЛ ХИЙСЭН АЖЛЫН АКТ.

2022 оны 09 сарын 25

Чойбалсан хот.

**Захиалагч байгууллага:** Петрочайна Дачин тамсаг ХХК 21-р талбай

**Хаяг:** Халх гол сум "Ялалт баг"

**Гүйцэтгэсэн байгууллагын нэр:** Эгэл-Альфа ХХК

**Хаяг:** Дорнод аймгийн Хэрлэн сум 6-р баг Ивээл хороолол

Байгаль орчин аялал жуучлалын сайд, Хүнс хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 02 угаар сарын 09-ны өдрийн А/25, А/46, А/76 тоот хамтарсан тушаалын 4-р хавсралтаар батлагдсан чанарын шаардлага хангасан бодисуудыг ашигласан.

**Халдваргүйтгэлд:** Хлорын шохой, ДП-2Т 0.02%, Нисор 1:1200 тунгаар гадна халдваргүйтгэлд тус тус найруулж уусмал бэлтгэн автомаксаар болон мотофомоор шүршиж мөн хлорын шохойг хэрэглэлээ.

**Шавжгүйтгэлд:** Карате/лямбдацигалотрин 0.2-0.3л/га буюу 20-30 мл тунгаар бодисыг гадна орчинд шавж авгалдайн устгалд, жилиу, дихлофос гель, ФАС зэргийг дотор орчинд тус тус шавжгүйтгэлд хэрэглэсэн.

**Мэрэгчгүйтгэлд:** Өгөөш /бромадиолон 0.5%-аар 20кг/ Открыс, ЭФА наалдуулагчийг хавсран хэрэглэсэн. Уг ажлыг гүйцэтгэхдээ явах замын дагуу болон тавиурын доогуур болон нүх сүвэнд онгоцонд хийж 1 метрийн зайтай тавьсан.

**Халдваргүйтгэл, шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэл хийсэн объектын нэр:**

- **21-р талбайн ТА-21 үйлдвэрлэлийн баазын нэгдсэн байгууламжийн бүх объектууд**
- **Гал тогоо**
  - Хятад гал тогоо
  - Гурил бэлтгэх өрөө
  - Ногоо бэлтгэх өрөө

- Хоолны заал
- Халуун бүтээгдэхүүн боловсруулах

**III. 21-р талбайн кемп /оффис сууцууд /сууц-57, оффис-44/ болон гадна зам талбай/**

**IV. Агуулах /махны хөлдөөгч, хоёр хүнсний агуулах, ус хадгалах газар, ногооны агуулах/**

**V. Эмнэлэг**

**VI. Ахуйн хатуу хог хаягдлын байгууламж**

**VII. Ахуйн шингэн хог хаягдлын байгууламж / ахуйн бохир усны худгууд / гадна талбай зэрэг бүх нэгжүүд хамрагдсан.**

#### **Ашигласан тоног, төхөөрөмж багаж хэрэгсэл:**

ОХУ-д үйлдвэрлэсэн "PY-4" маркийн 20л багтаамжтай цахилгаан автомакс, мананцар үүсгэгч "Atomizer DS350", гар автомакс, мотофом, хүйтэн мананцар үүсгэгч "YF-500", халуун мананцар үүсгэгч буу, цахилгаан жин, хэмжээт шилэн сав /хуванцар/, ХАБЭА-д хамгаалалтын хувцас, нэг удаагийн хувцас, хошуувч, N95 маск, нэг удаагийн малгай, резинэн бээлий, зөөврийн эмийн сан.

#### **Гадна орчин кемпийн гадна орчин:**

Халдваргүйтгэлд ахуйн шингэн, хатуу хог хаягдлын талбай болон ахуйн бохир усны худгуудад Хлорын шохойг нунтгаар , ДП-2Т 0.02% , Нисор 1:1200 тунгаар тус тус найруулж уусмал бэлтгэн автомаксаар болон мотофомоор шүршиж хэрэглэлээ.

#### **Гүйцэтгэгч компанийн бүрэлдэхүүн:**

Эрүүл ахуйч Ж.Мөнхцэцэг, химик Б.Ариунцэцэг, ариутгагч Б.Долгорсүрэн, байгаль орчны ажилтан М.Солонго техникийн ажилтан Ж.Эрдэнэцогт, жолооч Ч.Гэрэлчулуун нарын бүрэлдэхүүн ажилласан.

#### **Хяналт тавьсан ажилтанууд:**

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан дэд менежер Б.Сүхбат, Цацрагийн хяналтын ажилтан А.Алтан-од, төв кемпийн оффис болон сууцын ойр орчим талбайд эмч Х.Уугантогос, нэгдсэн байгууламжид Хөдөлмөр аюулгүй ажиллагааны ажилтан Э.Болорчимэг нар

#### **Байлцсан ажилтанууд:**

Нэгдсэн ТАХ II - мэдээний ажилтан Ж.Адъяасүрэн, оператор /бохир ус/ М.Сугаррагчаа, харуул хамгаалалтын ажилтан Б.Батнасан, үйлчлэгч Т.Одгэрэл, Б.Мөнхцэцэг, гадна орчинд ахуйн шингэн, хатуу хог хаягдлын талбайд ялгах



цехийн туслах ажилтан Б.Батдорж нарыг байлцуулан ажиллаа.

**Өгсөн зааварчилгаа:**

Уг ажлыг хийхийн өмнө цэвэрлэгээг сайтар хийсэн байхаас гадна мэрэгч орж болзошгүй нүх, сүвийг бөглөх, ажлын дараа устгагдсан мэрэгч, шавжийг цэвэрлэн холдуулах, өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээнд халдваргүйтгэлийн бодисыг зааврын дагуу тогтмол хэрэглэх, ариутгалын бодистой харьцаж байгаа тохиолдолд хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийг тогтмол хэрэглэх зэрэг зааварчилгаа өгөв.

**Ажлын гүйцэтгэлтэй танилцсан:**

ХАБЭАХ дэд менежер



Б.Сүхбат

**Ажлын гүйцэтгэлд хяналт тависан:**

НБХАА ажилтан



Э.Болорчимэг

Цацрагийн хяналтын ажилтан



А.Алтан-од

**Акт бичсэн:**

Эрүүл ахуйч



Ж. Мөнхцэцэг

**ХӨРСНИЙ ДЭЭЖ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН  
ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 10 сарын 8-ны өдөр

Тамсаг XXI талбай

"Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Тамсаг XXI талбайн 30 цооногийн өрмийн шингэн хаягдлын санд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайгаас MNS 3298-90 стандартын дагуу 120 ширхэг (1 цооноогоос 4 ширхэг) хөрсний дээж авч, 1 хувь болох 30 ширхэг дээжийг тус компанийн ХАБЭАБО-ны хэлтэст хүлээлгэн өгөв. Үүнд:

№	Цооногийн дугаар	Координат		№	Цооногийн дугаар	Координат	
		X	Y			X	Y
1	N696-454	116°48'14.29"	47°25'56.02"	16	N522-182	117°02'07.49"	47°39'35.17"
2	N508-264	116°57'09.57"	47°38'33.58"	17	N520-180	117°02'09.97"	47°39'41.42"
3	N510-262	116°57'21.60"	47°38'36.36"	18	N518-182	117°02'00.60"	47°39'43.49"
4	N508-260	117°57'24.12"	47°38'42.00"	19	N516-184	117°01'50.42"	47°39'46.50"
5	N508-256	116°57'32.47"	47°38'46.59"	20	N518-186	117°01'45.05"	47°39'39.55"
6	N510-254	116°57'48.93"	47°38'43.57"	21	N498-138	117°06'50.68"	47°44'33.79"
7	N508-252	116°57'48.39"	47°38'49.51"	22	N500-136	117°04'24.59"	47°41'20.77"
8	N508-248	116°58'01.94"	47°38'55.36"	23	N500-128	117°04'53.05"	47°41'29.35"
9	N506-250	116°57'51.53"	47°38'56.43"	24	N496-124	117°04'58.29"	47°41'44.85"
10	N506-246	116°58'02.97"	47°39'01.15"	25	N452-98	117°04'51.15"	47°43'18.27"
11	N504-248	116°57'55.16"	47°39'02.17"	26	N440-66	117°06'42.32"	47°44'17.93"
12	N504-246	116°58'03.12"	47°39'07.60"	27	N438-66	117°06'46.33"	47°44'23.47"
13	N504-206	117°00'01.85"	47°39'42.57"	28	N436-64	117°04'14.55"	47°41'23.30"
14	N522-188	117°01'44.16"	47°39'30.66"	29	N438-62	117°07'03.26"	47°44'28.84"
15	N520-184	117°01'56.49"	47°39'35.05"	30	N440-60	117°07'14.09"	47°44'25.52"

Хүлээлгэн өгсөн:

Байгаль Тандалт ХХК-ийн менежер



Б. Билгүүн

Хүлээн авсан:

Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тамсаг XXI талбайн  
ХАБЭАБО-ны хэлтсийн БО-ны мэргэжилтэн



Б. Алтангэрэл

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН АКТ

2022 оны 05 сарын 20 өдөр

№003

Тослийн нэр байршил: Дорнод аймаг, Халхгол сум, БХГ-г Газрын тосны 21-р талбай.

- Ажил гүйцэтгэгч тал: Экоцикл ХХК
- Ажил захиалагч тал: "Петрочайн Дачин Тамсаг" ХХК
- Шалгаж хүлээн авсан ажлын нэр: "Хориннэгдүгээр талбайн хатуу хог хаягдлыг устгах ажил"
- Гэрээний дугаар: "DQYT-GKGS-2022-FW-310"
- Ажлын даалгаврын биелэлт: Гэрээт ажлыг шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн
- Ажил дууссан огноо /он, сар, өдөр/: 2022.05.20
- Ажил гүйцэтгэлийг магадлан тайлан, фото зураг гэх мэт баримт бичгийн бүрдэл: Тайлан гүйцэтгэлийг хянаж баталгаажуулсан

Ажил хүлээлцэж авсан комиссын шийдвэр:

Гэрээний дагуу гүйцэтгэсэн тал хүлээж авсан

/Гэрээт ажлын судалгааны тайлан, стандарт норм, ажлын даалгаврын биелэлт хангаж буй эсэх, хүлээн авсан эсэх эгвэл засах/

ЗАХИАЛАГЧ ТАЛ:

"ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ"

ХХК-ийг ТӨЛӨӨЛЖ

Хүлээж авсан:

ЭМААБО-ны

Ажилтан ..... /Б.Сүхбат/

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ:

"ЭКОЦИКЛ" ХХК-ийг ТӨЛӨӨЛЖ

Хүлээлцэж өгсөн:

Захирал ..... /С.Шагдарсүрэн/



Зураг-6. Хатуу хог хаягдал



Аюултай хог хаягдал тээвэрлэсэн акт  
 Аюултай хог хаягдал тээвэрлүүлэгчийн мэдээлэл



1 Аж ахуй нэгжийн нэр: "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-н XXI талбай  
 Аюултай хог хаягдал тээвэрлэгчийн мэдээлэл

2 Аж ахуй нэгжийн нэр: "Түмэн эгшиг" ХХК

№	Хог хаягдлын төрөл	Бүртгэлийн дугаар	Тээвэрлэсэн хэмжээ	Хэмжих нэгж
1	Хортой бодисоор бохирдсон шингээгч бохир алчуур материал /Эрээн хучлага/	150201	396	м³
2	Задгай бодисын шуудай, арчих материал	150201	743	м³
3	Контейнер 1 /химийн бодисын шуудай/	150109	40.84	м³
4	Контейнер 2 /химийн бодисын шуудай/	150109	50.255	м³
5	18 литрийн химийн бодисын сав /будаг/	150109	193	ширхэг
6	60 литрийн химийн бодисын сав /хуванцар сав/	150109	64	ширхэг
7	Галын хор /2кг/	160502	37	ширхэг
8	Галын хор /4кг/	160502	18	ширхэг
9	Галын хор /8кг/	160502	76	ширхэг
10	Галын хор /35кг/	160502	3	ширхэг
11	Ремен, дугуй	160101	63.91	м³
12	Хуруу батерей	160601	124	ширхэг

Хүлээлгэн өгсөн:

"Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ний ХАБЭАБО-ны хэлтсийн менежер: Н.Н.Н /Начин

"Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ний ХАБЭАБО-ны хэлтсийн менежер: А.П.П /Ан Пинг

"Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ний ХАБЭАБО-ны хэлтсийн дэд менежер: Б.Сүлдбаяр /Б.Сүхбат

"Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ний ХАБЭАБО-ны хэлтсийн мэргэжилтэн: Б.Сүлдбаяр /Б.Сүлдбаяр

Хүлээн авсан:

"Түмэн эгшиг" ХХК-ний захирал: Г.Чинзориг

"Түмэн эгшиг" ХХК-ний менежер: Б.Одбаяр



## ДААТГАЛЫН ГЭРЭЭ

2021 оны ....-р сарын .....-ны өдөр

№ *ДРТ-ГКС-2021-RZBX-6*

Нэг талаас 2062089 тоот регистрийн дугаартай АРД ДААТГАЛ ХК (цаашид Даатгагч гэх), нөгөө талаас 2075385 тоот регистрийн дугаартай ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ МОНГОЛ ХХИ ХХК (цаашид Даатгуулагч гэх) нар дор дурдсан даатгалын гэрээг харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгээр байгуулав.

### **БҮЛЭГ НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ** **НЭГ. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Энэхүү гэрээгээр нэг талаас даатгуулагч нь энэхүү гэрээний хавсралтанд дурдсан даатгалын зүйлийг даатгуулж даатгалын хураамж төлөх, нөгөө талаас даатгагч нь даатгалын тохиолдол болсон нөхцөлд даатгалын зүйлд учирсан хохирлыг даатгуулагчид нөхөн төлөх харилцааг зохицуулна.
- 1.2 Хоёр тал энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай Монгол улсын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

### **ХОЁР. Даатгалын үнэлгээ, хураамж**

- 2.1 Энэхүү гэрээний даатгалын зүйлийн нийт үнэлгээ, хураамж дараах хэмжээтэй байна. Үүнд:

№	Даатгалын бүтээгдэхүүн	Урьдчилсан байдлаар нийт үнэлгээ (ам.доллар)	Хураамжийн хувь	Урьдчилсан байдлаар хураамжийн хэмжээ (ам.доллар)
1	Гэнэтийн ослын даатгал /21 талбай-Урьдчилсан байдлаар 247 ажилтан/	4,940,000.00	1%	49,400.00
<b>Нийт дүн</b>		<b>4,940,000.00</b>		<b>49,400.00</b>

- 2.2 Төлбөрийг Ард Даатгал ХК-ийн ХХБанкны **404048536** тоот ам.долларын дансанд шилжүүлнэ. Банкны swift код: **TDBMMNUB**
- 2.3 Даатгуулагч нь даатгалын хураамжийг энэхүү гэрээ байгуулагдсан даруй төлөх үүрэгтэй ба хэрэв даатгуулагч даатгалын хураамжийг хуваарийн дагуу хэсэгчилж төлөх нөхцөлтэйгөөр гэрээг байгуулах тохиолдолд бүтээгдэхүүний төрлөөс хамааруулан төлбөрийн хуваарийг гэрээнд хавсралтаар оруулж уг хуваарийн дагуу даатгалын хураамжийг төлнө.
- 2.4 Даатгагдсан зүйлсийн талаарх дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралтаар гарган энэхүү гэрээнд хавсаргана.
- 2.5 Даатгуулагч энэхүү гэрээний дагуу нөхөн төлбөр авсан тохиолдолд даатгалын үнэлгээ мөнхүү гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд тухайн хэмжээгээр буурах бөгөөд Даатгагчтай харилцан тохиролцсон бол зохих хураамжийг төлсний үндсэн дээр даатгалын үнэлгээг дахин сэргээж болно.

### **ГУРАВ. Даатгалын гэрээний хугацаа**

- 3.1 Энэхүү гэрээ нь 2021 оны .11.сарын .01.-ны өдрийн ..00.00.. цагаас 2022 оны .10...сарын ..31.... - ний өдрийн 23.59 цаг хүртэл хүчин төгөлдөр байна.
- 3.2 Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
  - 3.2.1 Хууль болон даатгалын гэрээгээр тогтоосон хугацаа дууссан;
  - 3.2.2 Даатгагч эсвэл даатгуулагч дампуурсан, татан буугдсан;
  - 3.2.3 Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тогтоосон;
  - 3.2.4 Даатгалын хугацааг гэрээнд зааснаас өмнө дуусгавар болгохоор 2 тал тохиролцсон;
  - 3.2.5 Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн
- 3.3 Гэрээний хугацаа дуусмагц Талууд гэрээг цуцлах санал тавиагүй бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэсээр байгаа бол энэхүү гэрээг гэрээний үндсэн хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 3.4 Даатгагч нь энэхүү даатгалын гэрээний хугацаа эхлэхээс өмнө даатгуулагчийн үйлдсэн үйлдэл эсвэл эс үйлдэл, үзүүлсэн үйлчилгээ, нийлүүлсэн бүтээгдэхүүн, үүссэн хохирол гаргаж болох нөхцөл байдлаас үүдэн учирсан хохирлын нэхэмжлэлийг нөхөн төлөхгүй. Мөн даатгалын хугацаа дууссанаас хойш даатгагчид мэдэгдсэн хохирол, гаргасан нэхэмжлэлийг нөхөн төлөхгүй.





#### ДӨРӨВ. Даатгагчийн эрх

- 4.1 Даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;
- 4.2 Даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах болон түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
- 4.3 Шаардлагатай гэж үзвэл даатгалын зүйлтэй дэлгэрэнгүй танилцах;
- 4.4 Даатгалын зүйлд даатгалын эрсдэл тохиолдох боломж гэрээ байгуулагдах үеэс нэмэгдсэн, ийнхүү нэмэгдэх нөхцөл орчин бүрдсэн тохиолдолд даатгалын хураамжийн хувь хэмжээг ихэсгэх буюу гэрээг цуцлах саналаа нөгөө талд тавих;
- 4.5 Даатгуулагч аюулыг санаатайгаар ихэсгэсэн бол даатгагч гэрээг цуцлах саналыг нөгөө талд тавих;
- 4.6 Даатгалтай холбоотой шаардлагатай гэж үзсэн мэдээллийг даатгуулагчаас бүрэн хэмжээгээр гаргуулах;
- 4.7 Даатгалын тохиолдол бий болсон тохиолдолд түүний шалтгаан, нөхцөлийг судлах, эрх бүхий байгууллагаар шалгуулах, шаардлагатай мэдээ, мэдээллийг Даатгуулагчаас шаардах;
- 4.8 Даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Даатгуулагчаас шаардах

#### ТАВ . Даатгагчийн үүрэг

- 5.1 Даатгалынхууль тогтоомж, даатгалын нөхцөлүүдийг даатгуулагчид танилцуулах, өөрийн санхүүгийн чадавхын талаарх мэдээллийг Даатгуулагчид өгөх;
- 5.2 Гэрээнд өөрөөр заагаагүй бол Даатгалын тохиолдол бий болсны улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгалын нөхөн төлбөр дээр нэмж даатгуулагчид нөхөн төлөх;
- 5.3 Даатгалын нөхөн төлбөрийг энэхүү гэрээнд заасны дагуу Даатгуулагчид олгох;
- 5.4 Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор Даатгуулагчтай бүх талаар идэвхтэй хамтран ажиллах.

#### ЗУРГАА. Даатгуулагчийн эрх

- 6.1 Даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;
- 6.2 Даатгагч шаардлагатай гэж үзвэл даатгалын зүйлийг даатгагчийн ажилтанд дэлгэрэнгүй танилцуулах;
- 6.3 Даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах болон түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
- 6.4 Даатгуулагчийн эрх үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;
- 6.5 Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд даатгагчийн санхүүгийн чадавхын талаар холбогдох мэдээ, мэдээлэл шаардах;
- 6.6 Даатгагчийн санхүүгийн чадвар муудсан гэж үзэх хангалттай үндэслэл бий болсон тохиолдолд гэрээг цуцлах саналыг нөгөө талд тавих;
- 6.7 Даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Даатгагчаас шаардах;
- 6.8 Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор Даатгагчтай бүх талаар идэвхтэй хамтран ажиллах;

#### ДОЛОО. Даатгуулагчийн үүрэг

- 7.1 Даатгуулагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 7.1.1 Даатгуулагч даатгалын хураамжийг энэхүү гэрээний 2.2-д заагдсаны дагуу даатгагчид төлөх;
  - 7.1.2 Даатгал болон даатгалын зүйлтэй холбоотой баримт, материал ба даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээ болон даатгалын нөхцөлүүдэд тусгагдсан баримт материалыг даатгагчид үнэн зөв, бүрэн гүйцэд, хууль зүйн дагуу бүрдүүлэн, даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн 90 хоногийн дотор хүлээлгэн өгөх;
  - 7.1.3 Даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой бүх арга хэмжээг авах;
  - 7.1.4 Даатгалын тохиолдол болсон тухай даатгагчид даатгалын тохиолдол болсноос хойш Улаанбаатар хотод бол нэн даруй, орон нутагт бол 72 цагийн дотор даатгагчийн 7720





0088 дугаарын утсанд урьдчилан мэдэгдэх ба утсаар мэдэгдэх боломжгүй тохиолдолд факс, албан бичиг гэх мэт аль боломжтой арга хэлбэрээр мэдэгдэх;

- 7.1.5 Даатгалын тохиолдол бий болсны улмаас учирсан хохирлын шалтгаан нөхцөл, хэмжээг үнэн зөв тогтоохын тулд хууль, хяналтын байгууллага, цагдаа, галын байгууллага, эмнэлэг зэрэг мэргэжлийн эрх бүхий холбогдох байгууллагын хүмүүс оролцсон комисс томилж акт тогтоох;
  - 7.1.6 Даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээнд тусгагдсан баримт, материалыг өөрийн зардлаар бүрдүүлэн даатгагчид хүлээлгэн өгөх;
  - 7.1.7 Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаас хойш шинээр бий болсон нөхцөл байдал, эрсдэлийн орчны өөрчлөлт, даатгалын тохиолдол бий болох боломжтой нөхцөл орчин бүрдсэн тухай даатгагчид нэн даруй мэдээлэх;
  - 7.1.8 Энэхүү гэрээнд заагдсан бусад үүрэг
- 7.2 Хэрэв, энэхүү гэрээний 11 дүгээр зүйлээс хойших зүйлүүдэд заагдсан Даатгуулагчийн хүлээх тусгай үүрэг болон мөнхүү гэрээний 7.1-д заагдсан Даатгуулагчийн хүлээх үүргийн хооронд зөрүү гарсан тохиолдолд 11 дүгээр зүйлээс хойших зүйлүүдэд заасан даатгуулагчийн хүлээх тусгай үүргийг дагаж мөрдөнө.

#### **НАЙМ. Гэрээний нууцлал**

- 8.1 Талууд гэрээний хугацаанд ажил үүргийн шаардлагаар олж мэдсэн, эзэмшиж, ашиглаж байсан баримт бичиг, мэдээ материал болон Талуудын бизнесийн ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай компанийн болоод харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээлэл, даатгалын хэмжээ, төлбөр, тооцоо, бусад үзүүлэлтүүд, байгууллага, хувь хүний нууц, Ноу-Хауг хугацаагүй чанд хадгална.
- 8.2 Гэрээнд зааснаас бусад асуудлаар Талууд өөр хоорондын ашиг сонирхлыг хөндсөн хөндлөнгийн аливаа үйлдэл хийхгүй байх үүрэгтэй.
- 8.3 Талууд эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн өөр хоорондын байгууллагын нууцыг чанд хамгаална.
- 8.4 Талууд ажил, үүргийн дагуу олж мэдсэн өөр хоорондын болон харилцагчийн аливаа мэдээллийг бусдад дамжуулах, хэвлэн нийтлэхгүй байх үүрэгтэй.

#### **ЕС. Гэрээний хариуцлага**

- 9.1 Хэрэв даатгагч энэхүү гэрээнд заасан журмын дагуу нөхөн төлбөрийг хугацаанд нь олгоогүй тохиолдолд хоног тутамд олгогдох нөхөн төлбөрийн 0.5 хувьтай тэнцүү хэмжээний алдангийг Даатгуулагчид төлнө.
- 9.2 Даатгалын гэрээг дараах үндэслэлээр цуцална. Үүнд:
  - 9.2.1 Даатгуулагч нь даатгалын хураамжийг энэхүү гэрээний 2.2 дугаар зүйлд заасны дагуу болон хэсэгчилж төлөх тохиолдолд гэрээнд тусгайлан заагдсан хугацаанд төлөлгүй хуанлийн 15хоногоос дээш хугацаагаар хожимдуулсан тохиолдолд гэрээг цуцлах саналыг Даатгагч нь Даатгуулагчид бичгээр хүргэх бөгөөд төлбөл зохих даатгалын хураамжийг төлөөгүй тохиолдолд Даатгагч гэрээг өөрийн санаачлагаар цуцлах эрхтэй;
  - 9.2.2 Даатгуулагч даатгалын тохиолдол бий болох нөхцөлийг ихэсгэсэн, энэ талаар шаардлагатай арга хэмжээ аваагүй;
  - 9.2.3 Даатгалтай холбоотой баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, хууль бус баримт бичиг бүрдүүлсэн;
  - 9.2.4 Энэхүү гэрээний 8 дугаар зүйлд заагдсан гэрээний нууцлалыг задруулснаас гэрээний аль нэг талын ашиг сонирхолд хохирол учирсан буюу учирч болох нөхцөл байдал бүрдсэн;
  - 9.2.5 Даатгагчийн санхүүгийн чадавх илт буурсан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тодорхойлогдсон.
- 9.3 Даатгалын гэрээ цуцлагдсанаас үүсэх үр дагавар
  - 9.3.1 Гэрээний аль нэг тал энэхүү гэрээний 8 дугаар зүйлд заагдсан гэрээний нууцлалыг задруулсны улмаас гэрээний нөгөө талд хохирол учирсан тохиолдолд учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
  - 9.3.2 Даатгагчийн санаачлагаар гэрээг хугацаанаас өмнө цуцлахад хүрвэл даатгуулагчийн төлсөн хураамжийг бүрэн хэмжээгээр Даатгуулагчид буцаан төлнө. Хэрэв, даатгалын нөхөн төлбөр олгосон байх үед даатгагчийн санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд даатгалын нийт хураамжаас орлогод тооцсон хураамжийг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно.





- 9.3.3 Даатгуулагчийн санаачлагаар гэрээг цуцалбал даатгалын нийт хураамжаас орлогод тооцсон хураамжийг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно. Хэрэв, даатгалын нөхөн төлбөр олгосон байх үед даатгуулагчийн санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд талууд биелэгдсэн үүргийн гүйцэтгэлийг харилцан бие биедээ бүрэн хэмжээгээр буцаан нөхөн төлнө.
- 9.4 Гэрээний аль нэг тал энэхүү гэрээнээс үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаан байгаа тохиолдолд гэрээнээс татгалзах тухай бичгэн мэдэгдлийг 1-ээс доошгүй сарын өмнө нөгөө талдаа өгнө. Гэрээний аль нэг тал гэрээнээс үндэслэлгүйгээр татгалзсанаас нөгөө талд учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 9.5 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсвэл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээг хүчин төгөлдөр болгох, гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгах, гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах боломжгүй нөхцөл байдлыг хүндэтгэн үзэх үндэслэл гэж үзнэ.

#### **АРАВ. Талуудын албан ёсны хаяг**

##### **ДААТГАГЧ –АРД ДААТГАЛ ХК**

Хаяг: Ард Санхүүгийн Нэгдлийн байр 2-р давхар, Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14200, Монгол улс  
Утас: 976- 7720 0088

##### **ДААТГУУЛАГЧ – ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ МОНГОЛ ХХИ ХХК**

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ж.Самбуугийн гудамж-32, Улаанбаатар-14200  
Утас: 976-77102777  
Факс: 976-77102777

#### **АРВАН НЭГ. Бусад зүйл**

- 11.1 Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын хууль тогтоомжид заагдсан эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.
- 11.2 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ нэмэлт, өөрчлөлтийг энэхүү гэрээнд бичгээр оруулсан нөхцөлд уг өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 11.3 Талууд энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа асуудал, маргааныг Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү гэрээ болон гэрээний талуудын эрх тэгш байдлын үндсэн дээр аль болох эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд хэрэв талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.
- 11.4 Энэхүү гэрээг Монгол болон Хятад хэл дээр нийт 7 хувь үйлдсэн бөгөөд гэрээний эх хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.
- 11.5 Аливаа маргаан гарсан тохиолдолд Монгол хэл дээрх хувийг үндэслэл болгоно.

#### **БҮЛЭГ ХОЁР. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

##### **АРВАНХОЁР. ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛЫН ТУСГАЙ НӨХЦӨЛ**

- 12.1 Энэхүү даатгалын хэлбэрт хэрэглэгдэх нэр томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:
- 12.1.1 “**Даатгагч**” гэж Даатгалын тухай Монгол Улсын хуулийндагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Монгол улсын хуулийн этгээд болох АРД ДААТГАЛ ХК-ийг;
- 12.1.2 “**Даатгуулагч**” гэж өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын звйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан этгээдийг;
- 12.1.3 “**Даатгалын зүйл**” гэж эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхлыг;
- 12.1.4 “**Даатгалын эрсдэл**” гэж даатгалд хамрагдсан зүйлд хохирол учруулж болох нөхцөл, орчныг;
- 12.1.5 “**Даатгалын тохиолдол**” гэж даатгуулсан звйлд даатгалын эрсдэлийн улмаас учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;
- 12.1.6 “**Даатгалын хураамж**” гэж даатгуулагч даатгалын звйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
- 12.1.7 “**Даатгалын нөхөн төлбөр**” гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын звйлд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;





- 12.1.8 “**Даатгалын үнэлгээ**” гэж даатгуулж байгаа эд хөрөнгийн болон эдийн бус ашиг сонирхлын мөнгөн илэрхийллийн хэмжээг;
- 12.1.9 “**Өөрийн хүлээх хариуцлагын хэмжээ**” гэж даатгалын тохиолдлоос үүссэн хохиролд даатгагчийн олгох нөхөн төлбөрөөс хасагдах хэмжээ буюу даатгагдсан этгээдийн хариуцах мөнгөн төлбөрийн хэмжээг;
- 12.1.10 “**Даатгалын цэвэр хураамж**” гэж даатгалын нийт хураамжаас даатгалын мэргэжлийн оролцогчид төлсөн төлбөр, давхар даатгалын хураамжийг хассан дүнг;
- 12.1.11 “**Орлогод тооцсон хураамж**” гэж даатгалын цэвэр хураамжийн орлогоос тайлант хугацаанд ногдох хураамжийг орлогод тооцон авсан дүнг;
- 12.1.12 “**Гэнэтийн осол**” гэж гэнэтийн, гадны хүчний нөлөөгөөр бие махбодод гэмтэл, бэртэл учруулах гэнэтийн тохиолдол болсон нөхцөл байдлыг;
- 12.1.13 “**Тахир дутуугийн зэрэглэл тогтоолт**” гэж даатгуулагч бүх төрлийн гэнэтийн ослын улмаас эрүүл мэндээр хохирон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш бүрэн алдсан бөгөөд эмч нарын зөвлөгөөнөөр зэрэглэл тогтоосон нөхцөл байдлыг;
- 12.1.14 “**Нас баралт**” гэж даатгуулагчийн гэнэтийн осолд орсноос хойш 12 сарын дотор тухайн ослын үр дагаврын улмаас нас барах тохиолдлыг;
- 12.1.15 “**Хөдөлмөрийн чадварын түр алдалт**” гэж даатгуулагч гэнэтийн ослын улмаас эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн болон байнгын амбулаторийн хяналтанд байсан хуанлийн 90 хүртэлх хоногийг;
- 12.1.16 “**Ашиг сонирхол бүхий этгээд**” гэж даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авах эрх бүхий хувь хүн, хуулийн этгээдийг;
- 12.1.17 “**Зөвхөн ажил үүргээ биелүүлж явах үеийн**” гэж даатгуулагч хөдөлмөрийн болон бусад адилтгах гэрээний дагуу ажил хөдөлмөр эрхлэх, гүйцэтгэх, байгууллагын зохион байгуулалттай ажилд, тэмцээнд оролцох, томилолтонд явах, ажилдаа явах, буцах шууд замд байгаа үеийг;
- 12.1.18 “**24 цагаар**” гэж даатгуулагч зөвхөн ажил үүргээ биелүүлж явах үеэс гадна хувийн бусад ажил, амралтын бусад бүх цаг үеийг тус тус ойлгоно.
- 12.2 **Даатгалын эрсдэл**
- 12.2.1 **Үндсэн эрсдэл**
- 12.2.1.1 Бүх төрлийн гэнэтийн осол
- 12.3 Даатгалын зүйл, түүний үнэлгээ ба даатгалын хураамжийн хэмжээг дор дурдсан байдлаар тодорхойлно. Үүнд:

№	Даатгалын бүтээгдэхүүн	Урьдчилсан байдлаар нийт үнэлгээ (ам.доллар)	Урьчилсан байдлаар хураамжийн хэмжээ (ам.доллар)
1	Гэнэтийн ослын даатгал /21 талбай - Урьдчилсан байдлаар 247 ажилтан/	4,940,000.00	49,400.00

- 12.4 **Иргэдийн гэнэтийн ослын даатгалын нийт үнэлгээ 4,940,000.00 ам.доллар, хураамжийн дүн 49,400.00 ам.доллар.**
- 12.5 **Нөхөн төлбөрийн нөхцөл**
- 12.5.1 Даатгалын нөхөн төлбөрийг дараах материалыг үндэслэн олгоно. Үүнд:
- 12.5.1.1 Даатгуулагчийн өргөдөл; даатгуулагчийг хууль ёсны дагуу төлөөлөх эрх бүхий этгээдийн өргөдөл;
- 12.5.1.2 Даатгалын гэрээ, баталгааны эх хувь;
- 12.5.1.3 Даатгалын тохиолдол бий болсныг нотлох фото зураг, боломжтой бол хэргийн газар дээрээс баталгаажуулсан бусад нотлох баримтууд, эд мөрийн баримтууд;
- 12.5.1.4 Хохирлын шалтгаан, хэмжээ, зүйлийг эрх бүхий байгууллагаас тодорхойлсон акт, материал, баримт;
- 12.5.1.5 Мэргэжлийн холбогдох байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт;
- 12.5.2 Даатгалын тохиолдол үүссэн үед хохирлын хэмжээг тодорхойлохдоо даатгуулагч өөрийн зардлаар Монгол Улсад үнэлгээ хийх эрх бүхий үнэлгээчин, аудитаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ. Уг үнэлгээг талуудын аль нэг нь эс зөвшөөрсөн тохиолдолд талууд хамтран Монгол Улсад үнэлгээ хийх эрх бүхий үнэлгээчин, аудитыг сонгон, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх бөгөөд гарах зардлыг талууд хамтран хариуцна.
- 12.5.3 Даатгагчаас даатгуулагчид олгох нөхөн төлбөр болон энэхүү гэрээний 5.2-д заасан нөхөн төлбөрийн нийлбэр нь даатгалын үнэлгээнээс хэтэрч үл болно.





- 12.5.4 Даатгалын тохиолдол болсон үед Даатгагчийн нөхөн төлбөр хариуцсан албан тушаалтан нөхөн төлбөрийн баримтуудыг бүрэн гэж хүлээн авч, зохих баримт үйлдсэн өдрөөс хойш хуанлийн 14 өдрийн дотор энэхүү гэрээгээр тохиролцсон хэмжээнд олгоно. Хэрэв даатгагч нь даатгалын нөхөн төлбөр хүссэн баримт бичгийг хянах явцад нэмэгдэл мэдээлэл цуглуулах, төрийн эрх бүхий байгууллагаар шалгуулах шаардлага гарсан тохиолдолд энэхүү хугацааг сунгаж болно.
- 12.5.5 Хэрэв, даатгалын нөхөн төлбөртэй холбоотойгоор тухайн хэрэг төрийн захиргааны байгууллагад хянагдаж байгаа, шүүхийн журмаар хянан хэлэлцэгдэж байгаа нөхцөлд энэхүү гэрээний 12.5.4 дүгээр зүйлд заасан зохицуулалт үйлчлэхгүй.
- 12.5.6 Даатгалын тохиолдол бий болсны дараа даатгагч нөхөн төлбөрийг олгосон нөхцөлд буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.
- 12.5.7 Даатгалын нөхөн төлбөрийг зохих журмын дагуу олгосноос хойш Даатгуулагч гарсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн болох нь тогтоогдсон тохиолдолд Даатгуулагч нь олгогдсон нөхөн төлбөрийг үл маргах журмаар Даатгагчид бүрэн буцаан төлнө.
- 12.5.8 Даатгуулагчийн хүлээх хариуцлага нь бүхлээрээ буюу хэсэгчлэн өөр даатгалын гэрээгээр даатгагдсан бол нөхөн төлбөр нь даатгагчийн хүлээх хариуцлагын хүчин төгөлдөр буй бүх даатгалын гэрээнүүдийн хариуцлагын дээд хязгаарын нийлбэр дүнд түүний эзлэх хувиар даатгуулсан хариуцлагын хязгаараас тооцож олгоно.
- 12.5.9 Даатгалын зүйл нь Монгол Улсын иргэд болон гадаадын харъяат ба иргэний харъяалалгүй 18-аас дээш насны иргэдийн тахир дутуугийн зэрэглэл тогтоолголт, нас баралт байх тохиолдолд тахир дутуугийн зэрэглэл тогтоосон хугацаанаас хамааран дараах байдлаар нөхөн төлбөр олгоно. Үүнд:
- 12.5.9.1 Жилээс дээш хугацаагаар тогтоолгоход үнэлгээний 100 хувиар;
  - 12.5.9.2 6 сараас 12 сар хүртэл хугацаагаар тогтоолгоход үнэлгээний 50 хувиар;
  - 12.5.9.3 6 сар хүртэл хугацаагаар тогтоолгоход үнэлгээний 30 хувиар;
- 12.5.10 Даатгалын зүйл нь Монгол улсын иргэд болон гадаадын харъяат ба иргэний харъяалалгүй 18-аас дээш насны иргэдийн тахир дутуугийн зэрэглэл тогтоолголт, нас баралт болон хөдөлмөрийн чадвар түр хугацаагаар алдалт байх тохиолдолд даатгуулагч нь 90 хоног эмчлүүлээд тахир дутуугийн зэрэглэл тогтоолгосон бол хугацаанаас нь хамааруулан 12.5.9-д заасан хэмжээгээр нөхөн төлбөр авах ба эмчилгээний хоногоос шалтгаалан дараах байдлаар нэмж нөхөн төлбөр авна. Үүнд:
- 12.5.10.1 45 хүртэл хоног эмчлүүлсэн бол хуанлийн хоног тутамд үнэлгээний 0.3 хувиар;
  - 12.5.10.2 46-аас дээш хоног эмчлүүлсэн бол 12.5.10.1-д заасан хэмжээн дээр нэмж 46 дах хоногоос эхлэн 90 дэх хоног дуустал хоног тутамд үнэлгээний 0.5 хувиар;
- 12.5.11 Даатгуулагч гэнэтийн ослоор нас барсан тохиолдолд даатгалын үнэлгээний 100 хувиар тооцож нөхөн төлбөр авах ба нийт олгох нөхөн төлбөр нь даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй байна.
- 12.5.12 Нөхөн төлбөрийг эмчилгээний хугацаа дууссаны дараа тахир дутуугийн зэрэглэл тогтоолгосон эс тогтоолгосон шийдвэр гарсны дараа тооцож олгоно.
- 12.5.13 **Дараах тохиолдолд даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзана. Үүнд:**
- 12.5.13.1 Даатгуулагч даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, бүрдүүлэхээр завдсан;
  - 12.5.13.2 Даатгал хийлгэх үедээ даатгалын зүйлтэй холбоотой мэдээлэл худал буюу зөрүүтэй болон даатгалын асуулгыг үнэн зөв өгөөгүй бол;
  - 12.5.13.3 Даатгалын тохиолдол болсныг нотлох боломжгүй бол;
  - 12.5.13.4 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол гэмт хэргийн шинж чанар, зорилготойгоор үйлдсэн үйлдлийн улмаас учруулсан аливаа хохирол;
  - 12.5.13.5 Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлд гарсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн алдагдал;
  - 12.5.13.6 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээ болон даатгалын нөхцөлүүдэд тусгагдсан баримт материалыг даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн 90 хоног дотор хүлээлгэн өгөөгүй бол;
  - 12.5.13.7 Гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна учирсан аливаа хохирол;
  - 12.5.13.8 Байлдааны зэвсэг хэрэглэх, атомын болон цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхит цэнэгийн нөлөөгөөр үүссэн хохирол;
  - 12.5.13.9 Дайн, дайны шинжтэй тэмцэл, хувьсгал, маргаан, булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, мина хаях, бөмбөг дэлбэлэх зэрэг үйл ажиллагаанаас үүдсэн хохирол;





- 12.5.13.10 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол нийгмийн эмх замбараагүй байдал, иргэний бослого, үймээн, гэмт халдлага, террорист болон улс төрийн шинж чанартай үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол;
- 12.5.13.11 Даатгуулагч нь даатгалд хамрагдахаас өмнө учирсан ослын улмаас олсон гэмтлийн урхаг, хор нөлөөг эдгэрүүлэх, сэргийлэх зорилгоор дахин эмчилгээ хийлгэж эмнэлэгт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн бол;
- 12.5.13.12 Ердийн болон халдварт өвчний улмаас хэвтэж эмчлүүлсэн болон тахир дутуугийн зэрэглэл тогтоолгосон, рашаан сувиллын амралтын газар сувилуулж, эмчлүүлсэн бол;
- 12.5.13.13 Даатгуулагч нь санаатайгаар өөрийн биед гэмтэл учруулсан, амиа хорлосон, амиа хорлохыг завдсан бол;
- 12.5.13.14 Мэргэжлийн спортын, уралдаан тэмцээн мөн бүхий л дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгслээр уралдаан тэмцээнд оролцсон, уулын спорт, агаарын бүхий л спорт болон шүхрийн спортод оролцсон бол;
- 12.5.13.15 Даатгуулагч, түүний ажилтны сэтгэл санааны хямрал, сэтгэцийн эмгэг, эрх зүйн чадамжгүй үе, саа өвчний улмаас болон түр зуурын шокын байдлаас үүдсэн гэмтэл бэртэл болон согтууруулах ундаа мөн мансууруулах бодис хэрэглэснээс үүдсэн хохирол;
- 12.5.13.16 Даатгуулагчийн ажил мэргэжлээс шалтгаалах өвчин болон удаан хугацааны туршид үүссэн нуруу нугасны гэмтэл;
- 12.5.13.17 Даатгуулагчийн 90-ээс дээш хоногт эмчлүүлсний төлбөр;
- 12.6 **Даатгуулагчийн хүлээх тусгай үүрэг**
- 12.6.1 Даатгалын тохиолдлоор хүний амь нас хохирсон бол энэ тухай даатгагчид 48 цагийн дотор урьдчилан мэдэгдэх (утас, факс, албан бичиг гэх мэт аль боломжтой арга хэлбэрээр);
- 12.6.2 Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж буй эрсдэлийн нөхцөл байдал болон хураамжийг тогтоох бусад мэдээлэл, түүнчлэн нас, хүйс, эрүүл мэндийн байдал архаг хууч өвчний талаар бүхий л мэдээллээр үнэн зөв хангах;
- 12.6.3 Даатгуулагч нь даатгалын тохиолдол болмогц яаралтай эмнэлэгт хандан гэмтэл бэртлийг даамжруулж хүндрүүлэлгүй эмчилгээ үйлчилгээ хийлгүүлэх;
- 12.6.4 Энэхүү гэрээний дагуу даатгалд шинээр хамрагдах ажилтан, албан хаагчдын мэдээллийг тухай бүрт Даатгагчид и-мэйлээр хүргүүлэх бөгөөд Даатгагч нь зохих өөрчлөлтийг ажлын 3 хоногт хийж гүйцэтгэн Даатгуулагчид мэдэгдэнэ.
- 12.6.5 Шинээр даатгалд хамрагдаж буй ажиллагсдын даатгалын хураамжийг сарын 0.09 хувиар бодож, гэрээний хугацаа дуусах сар хүртэлх хугацаагаар тооцоолж нэхэмжлэхийг и-мэйлээр хүргүүлнэ. Даатгагдсан ажилтан ажлаас гарсан эсвэл ажлаас халагдсан тохиолдолд өөр шинээр ажилд орсон шинэ ажилтаныг орлуулан, нэмэлт хураамжгүй бүртгэнэ. Энэ заалт нь гэрээний хугацаанд хүчин төгөлдөр байх.
- 12.6.6 Гэрээний хугацаа дуусахаас өмнөх 90 хоногт шинээр ажилтан нэмж даатгах бол 12.6.5 дах заалт үйлчлэхгүй ба талууд харилцан тохиролцож тусгай нөхцөлөөр даатгана.


БАТЛАВ:

АРД ДААТГАЛ ХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



БАТЛАВ:

ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ  
МОНГОЛ XXI ХХК







	арга хэмжээний биелэлт										
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5									
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	10									
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5									
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5									
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5									
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5									
	Нийт оноо	100									

Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт биелэлтээс нь хамааран авсан байвал зохих оноог тогтоосон ба ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны энгийн арифметик дунджийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тооцож гаргана. Гишүүдийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн онооны энгийн арифметик дунджийн нийлбэр нь нийт оноо болно. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн нийт оноо нь 90-аас доош байвал төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж үзнэ. Тухайн жилд дүйцүүлэн хамгаалах ажил

төлөвлөгдөөгүй бол нөхөн сэргээх арга хэмжээ рүү, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцно.

Ажлын хэсгийн дарга: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Гишүүд:

Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

\_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Байгаль орчны асуудал хариуцсан газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн \_\_\_\_\_

/ \_\_\_\_\_ /

Сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Хүлээн зөвшөөрсөн:

\_\_\_\_\_ ХХК-ийн захирал